

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРОО

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр, Даваа гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 8
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	9 – 57

1.	<i>Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	10 – 17
2.	<i>Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	17 – 50
3.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай/</i>	50 – 51
4.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/</i>	51 – 53
5.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/</i>	53 – 55

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 9 дүгээр сарын 29-ний өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 57 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

*Томилолттой: Б.Дэлгэрсайхан, Д.Пүрэвдаваа;
Чөлөөтэй: Х.Баттулга, М.Нарантуяа-Нара, Н.Учрал.*

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдээгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасаням, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, мөн яамны Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Макро эдийн засгийн бодлогын газрын мэргэжилтэн Т.Мягмаржав, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Т.Мөнхцэцэг, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Гантуяа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар, А.Энхбат, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын менежер Б.Долгорсүрэн, Санхүүгийн аудитын газрын менежер Д.Энхдалай, А.Цогтбаяр, С.Нацагдорж, Санхүүгийн аудитын газрын аудитор Э.Бат-Эрдэнэ, Гүйцэтгэлийн аудитын менежер Ю.Энхтуяа, Гүйцэтгэлийн аудитын аудитор Д.Нямжаргал, Б.Идэрбалжинням, Нийцлийн аудитын менежер Э.Баттогтох, Улсын дээд шүүхийн Тамгын

газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн сургалт судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, Улсын дээд шүүхийн ерөнхий нягтлан бодогч А.Эрдэнэцэц, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Ч.Ариунтуяа, мөн хорооны ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал, Хүний эрхийн Үндэсний Комиссын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Д.Ёндонжамц, Хүний эрхийн Үндэсний Комиссын ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээжид, Авлигатай тэмцэх газрын ерөнхий нягтлан бодогч Т.Цэрмаа, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга Ч.Цасчихэр, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албаны дарга Л.Очирсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэв.

Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, Улсын дээд шүүхийн ерөнхий нягтлан бодогч А.Эрдэнэцэц, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, мөн зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Ч.Ариунтуяа, Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга Д.Мөнхзориг, ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Д.Ёндонжамц, ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээжид, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, мөн газрын ерөнхий нягтлан бодогч Т.Цэрмаа, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Цагаатгах ажлыг удирдан удирдан зохион байгуулах Улсын комиссын нарийн бичгийн дарга Ч.Цасчихэр, ажлын албаны дарга Л.Очирсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Гантуяа, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч Г.Базаргүр, ахлах шинжээч Б.Хатантуул, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч Д.Сүхболд, мөн газрын Санхүү, ар талын албаны дарга Д.Батчулуун, Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч Ж.Бямбасүрэн, Хил хамгаалах ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, ерөнхий нягтлан бодогч Ц.Чойжилсүрэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга А.Намсаманд, Шүүхийн

шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Санхүү, үйлдвэр хөрөнгө оруулалтын газрын дарга Т.Өнөртуяа, мөн газрын Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Энх-Од, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Давааням, мөн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Энхнаран, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга Ж.Буянбат, мөн газрын Санхүү, хангамжийн газрын дарга Х.Саранчимэг, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, мөн газрын Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга Ж.Солонго, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга М.Түвшинжаргал, мөн хүрээлэнгийн Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч Н.Уранчимэг, Архивын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэндсүрэн, мөн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Лхамсүрэн, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн дарга П.Энхбаяр, мөн төвийн Захиргаа, удирдлагын газрын Санхүү, ар талын тасгийн дарга Н.Уянга, Дотоод хэргийн их сургуулийн захирал О.Зоригт, Дотоод хэргийн их сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ч.Лхагважав, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Н.Одонгуа, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн штабын дарга бөгөөд Инновац, хөгжлийн асуудал эрхэлсэн дэд захирал Г.Бат-Эрдэнэ, мөн эмнэлгийн Санхүү, хангамжийн албаны дарга М.Мөнхбаяр, Хууль зүйн туслалцааны төвийн дарга Л.Уянга, ахлах нягтлан бодогч Л.Болор-Эрдэнэ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын албаны дарга Л.Нямгэрэл, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Гантуяа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар, А.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, С.Эрдэнэболд, Ц.Сандаг-Очир, Да.Цогтбаатар нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч Д.Сүхболд, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн

дарга З.Баасанням, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч Ж.Бямбасүрэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга А.Намсаманд, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн А.Энхбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, О.Алтангэрэл, Ц.Сандаг-Очир, Л.Мөнхбаатар, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18

61.1 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 57 минут үргэлжилж, 25 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 54 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН

ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр, Даваа гараг
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим
12 цаг 57 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаан ирц бүрдсэн тул эхэлж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Ирц Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Оюунсайханы Алтангэрэл, Хүрэлбаатарын Баасанжаргал, Баярмаагийн Баярбаатар, Жудагийн Баярмаа, Дашдондогийн Ганбат, Салдангийн Одонтуяа, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Гончигдоржийн Уянгахишиг, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүдийн 56 хувийн ирцтэйгээр ирц бүрдсэн байна.

Тийм учраас хурлыг эхлүүллээ. /алх цохив/ Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал өнөөдөр 5 асуудал байгаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн. Одоо энэ бол хоёрдахь хэлэлцүүлэг явж байна.

Хоёр. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл. Засгийн газар 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хоёр дахь хэлэлцүүлэг явж байгаа.

Гурав дахь асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай асуудал байгаа.

Дөрөвдүгээр асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Ажлын хэсэг байгуулах тухай.

Тавдугаар асуудал бас Байнгын хорооны тогтоолын төсөл. Ажлын хэсэг байгуулах тухай байгаа.

Ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудлыг баталлаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хоёр дахь хэлэлцүүлэг,
Санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./**

Нэгдүгээр асуудал. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Түрүүн би хэлсэн байгаа. Энэ оны 9 дүгээр сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн байгаа. Хоёр дахь хэлэлцүүлэг явж байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдон хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Үндэсний аудитын газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам гэсэн байгууллагуудаас төлөөллүүд оролцож байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн,

Үндэсний аудитын газраас Баясгалангийн Долгорсүрэн Санхүүгийн аудитын газрын менежер, Доржсүрэнгийн Энхдалай Санхүүгийн аудитын газрын менежер, Агваанцэрэнгийн Цогтбаяр Санхүүгийн аудитын газрын менежер, Сүхбаатарын Нацагдорж Санхүүгийн аудитын газрын менежер, Энхсайханы Бат-Эрдэнэ Санхүүгийн аудитын газрын аудитор, Юрагийн Энхтуяа Гүйцэтгэлийн аудитын менежер, Дашнямын Нямжаргал Гүйцэтгэлийн аудитын аудитор, Баяндаваагийн Идэрбалжинням Гүйцэтгэлийн аудитын аудитор, Энх-

Амгалангийн Баттогтох Нийцлийн аудитын менежер гэсэн бүрэлдэхүүнтэйгээр аудитын газар оролцож байна.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Цасчихэрийн Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, Туваанжавын Мягмаржав Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын мэргэжилтэн, Тамирын Мөнхцэцэг Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн.

Сангийн яамнаас Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна.

Эрхлэх асуудлын хүрээнд ажлын хэсэг оролцож байгаа. Л.Мөнхбаатар Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Б.Жавхлан Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Н.Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Гантуяа Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга.

Улсын дээд шүүхээс С.Заяадэлгэр Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга, Д.Эрдэнэчимэг Шүүхийн сургалт судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал, А.Эрдэнэцэц Улсын дээд шүүхийн ерөнхий нягтлан бодогч.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Н.Мөнгөнцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Б.Эрдэнэтулга Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, С.Наранбилэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга.

Шүүхийн сахилгын хорооноос Ч.Ариунтуяа Шүүхийн сахилгын хорооны дарга, Д.Мөнхзориг Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга, Б.Ариунжаргал Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны ерөнхий нягтлан бодогч.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос Д.Сүнжид Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Д.Ёндонжамц Хүний эрхийн Үндэсний Комиссын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, Б.Бадамсэрээжид Хүний эрхийн Үндэсний Комиссын ерөнхий нягтлан бодогч.

Авлигатай тэмцэх газраас З.Баасанням Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, Т.Цэрмаа Авлигатай тэмцэх газрын ерөнхий нягтлан бодогч.

Улсын ерөнхий прокурорын газраас С.Гансэлэм Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссоос Ч.Цасчихэр Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга, Л.Очирсүрэн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албаны дарга гэсэн бүрэлдэхүүнтэйгээр бас ажлын хэсэгт одоо манай салбарын төлөөлөл оролцож байна.

Хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг би танилцууллаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэх бөгөөд хуулийн төсөл 2 зүйлтэй.

Гишүүн хуулийн төслийн зүйлтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж болно.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү. П.Сайнзориг гишүүнээр тасаллаа. П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хууль хэлэлцэж байгаа.

Яах вэ, зүгээр нэг зүйл байна. Мэдээж асуудлууд буюу төсвийн орлого бүрдүүлэх талаасаа ч гэсэн гадаад, дотоод нөхцөл байдал нэлээн амаргүй байгааг ойлгож байгаа.

Түрүү жил хөгжлийн төлөвлөгөө баталж байхад Эдийн засаг, хөгжлийн яам төрийн албан хаагчдыг 9 хувиар бууруулна гэсэн. Энэ маш тодорхой шалгуургүйгээр орж ирсэн. Гишүүд ч асуугаад асуугаад хариултаа авч чадаагүй. Тэгээд хүчиндээд батлаад явсан. Тийм. Энэ дээр ерөнхийд нь би бас яримаар байгаа юм.

Гэтэл энэ болсон асуудал чинь ерөнхийдөө төсвийн урсгал зардал талдаа бууруулах оролдлого байгаа боловч үүний цаана төрийн одоо үйлчилгээний хэвийн хүний эрх хангагдах, хүний эрхийн зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаа чинь бас орхигдож байгаа юм.

Энэ чинь цааш цаашдаа урсгал зардлуудыг үүнээс ч илүү нэмэгдүүлэх байдал руу орно гэсэн үг. Би уг нь Ц.Сандаг-Очир даргын хэлж байгаа шиг зарчим гэж байгаа юм. Дээрээсээ шаардлагагүй орон тоонуудыг бууруулах байдлаараа юм уу, нэгтгэх байдлаар явах болов уу гэж байтал жигдхэн шиг ерөөсөө байгууллага болгон дээр 9 хувь танагдсан.

Энэ өөрөө эргээд засаглалын нэг эрх мэдэл болох шүүх эрх мэдлийн байгууллагууд ч гэсэн явсан юм билээ. Явсан юм билээ. Улсын Их Хурлын дэргэдэх бас тодорхой байгууллагууд явсан юм билээ.

Гэхдээ зарим байгууллагууд маань хэтэрсэн нь үнэн. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс эхлээд захиргааны ажил чинь данхайсан байгаа. Гэтэл шүүгч нарынх нь туслахууд нь хүрэлцэхгүй байгаа. Шаардлагагүй захиргааны шүүгчдийг томилж байгаа. Ийм юмнууд байгаа.

Тэгэхдээ өнөөдөр энэ том 9-хөн үзүүлэлтээр бид батлах гэж байгаа боловч энэ суурь зарчим бас засаглал хоорондын юмнууд дээр нэлээн нөхцөл байдлуудыг хүндрүүлэх байдалтай байгаа шүү.

Тэгээд энэ дээр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ч юм уу тодорхой байр суурийг нь сонсмоор байна. Яах вэ, төсвийн хүрээ явж байгаа боловч энэ урсгал зардлыг бууруулж байгаатай холбоотой танай хэвийн үйл ажиллагаа цаашдаа шүүх эрх мэдлийн байгууллага явах уу? Энэ хууль сахиулах байгууллагуудыг бас нэг ямар нөхцөл байдалтай байх вэ гэдэг дээр Хууль зүйн сайдын байр суурийг сонсмоор байгаа юм. Энэ бол бас чухал шүү.

Нэг ийм юм байгаа. Манайд. Тодорхой орон тоонуудыг баталж аваад цалингийн хэмнэлт хийж байгаад одоо ингээд дур дураараа цалин өсгөдөг энэ гажгаасаа бид гарах ёстой. Энэ систем манай Хууль зүйн яаман дээр цааш цаашдаа бодлогын дэмжлэг үзүүлэх асуудал дээр чинь бид хэдийн зан үйл гэдэг юм уу, шийдвэр оруулалтын хандлагын асуудал чинь сөргөөр нөлөөлж байгаа шүү.

Ерөнхийдөө батлаад 100 орон тоо гэж авангуутаа 80 хүн ажиллуулдаг. 20-ийг авдаг. Өөрсдөө шүүх эрх мэдлийн байгууллагууд дур дураараа цалингаа нэмэнгүүт энэ дээр хашилт. Одоо юу гэдэг юм. Зохицуулалт хийхээс өөр аргагүй байдал руу орж. Энэ ч одоо ерөөсөө шаардлагагүй орон тоо байсан юм байна гээд хасах жишээний.

Тэгэхээр энэ 9 үзүүлэлтийн нэг бол улсын төсвийн зарлага буюу урсгал зардалтай холбоотой тоон үзүүлэлтүүд байгаа. Энэ хууль зүйн салбарын асуудлууд чинь цаашдаа хэвийн явж чадах юм уу гэдэг дээр би хоёр гол институцийг л сонсьё гэж бодож байна. Гүйцэтгэх эрх мэдэл болон шүүх эрх мэдлийн байгууллагыг төлөөлж байгаа хоёр хүн бас нэг байр сууриа... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Н.Мөнгөнцэцэг дарга. Индэр дээрээс. Та тэндээс хариултаа өгчих өө. Тэгээд дараа нь Л.Мөнхбаатар сайд бас бэлдэж байгаарай.

Н.Мөнгөнцэцэг: Хууль зүйн байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Өнөөдөр 2026 оны төсөв хэлэлцэж байна. Үүнтэй холбоотойгоор шүүхэд шүүн таслах ажиллагаа явуулахад доголдол гарах уу гээд.

Тэгэхээр миний хувьд нэгдүгээрт юуг илэрхийлмээр байна вэ гэхээр хуульд заасан Үндсэн хуулийн зарчим байгаа юм. Шүүхийн төсвийг бууруулахгүй байх зарчим. Тэгээд шүүхийн бие даасан байдлыг хангах гол механизм, үндсэн баталгаа нь ерөөсөө эдийн засгийн баталгаа байгаа юм.

Гэтэл 2025 оны батлагдсан төсвөөс манай төсөв 29.8 хувь буурсан байгаа. Урсгал зардал нь 13.2 хувь.

2025 оны тодотголоос 16.2 хувь буурсан. Хууль зүйн байнгын хорооны хянасан төсвөөс бүр 60.0 хувь буурсан үзүүлэлттэй байгаа.

Тэгэхээр шүүхийн төсөв төрөөс санхүүжнэ. Тэгээд шүүх бие даасан төсөвтэй байна гэсэн энэ нөхцөл хангагдахгүй байгаа гэж үзэж байгаа.

Тэгээд шүүх өөрийн төсөв Хууль зүйн байнгын хороогоор хянуулаад өөрөө улсын төсөвт нэгтгүүлэх зохицуулалт нь байгаа. Мөн түүнчлэн Та бүгдийн 2024 оны шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогод шүүхийн төсвийг 2 хувьд хүргэнэ гэсэн тогтоол маань өөрөө хэрэгжиж байгаа. Гэтэл бодит байдал дээр манай шүүхийн төсөв ямар хэмжээгээр буурч байгааг Та бүхэн харж байна.

Хоёрдугаарт, 53 дугаар тогтоолоор нийт ажиллах шүүгчдийн тоо өөрөө 699. Гэтэл нийт улсын хэмжээнд ажиллаж байгаа шүүгчийн тоо 517 байгаа.

Ингээд бид ачааллын тухайд аргагүй нэг шүүгчид оногдож байгаа ачаалал их байгаа учраас бид урамшууллыг 2023 оны сүүлийн хагасаас олгоод эхэлсэн байгаа.

Тэгэхээр 2024 онд нийт 514 шүүгчээс эхний хагас жилд 333 шүүгч. Энэ нь 64.8 хувь нь. Хоёрдугаар улиралд 309 буюу 60.1 хувь. Шүүгч нөгөө урамшууллыг авсан байгаа.

Гэтэл энэ яг ачааллаараа тооцоод бид 53 дугаар тогтоолд 699 шүүгч ажиллахаас одоо бид нарт нийт шаардлагатай шүүгчийн тоо 614 байгаа. Гэхдээ бид хэд үүнийг үнэхээр шүүгчийн сонгон шалгаруулалтын. Одоо бид 9 удаагийн сонгон шалгаруулалт явахад шүүгчийн орон тоогоо нөхөж чадахгүй байгаа гэдгийг бид бүхэн бүгдээрээ мэдэж байгаа.

Бид хэдийн гол баримталж байгаа бодлого шүүгчийн шаардлагаа өндөр тавина. Тэр тавьж байгаа шаардлагад нийцсэн ёс зүйтэй, хариуцлагатай шүүгч байх ёстой гэдгээр босго оноог ямар нэгэн байдлаар буулгаагүй. Энэ дээр чадваргүй, чадалгүй тийм шүүгчийг томилж, дараа нь салж чадахгүй байснаас хамгийн гол нь чадалтай, хариуцлагатай тийм шүүгчийг томилно гэдэг дээрээ бат зогсож байгаа.

Тэгээд бидний хувьд сонгон шалгаруулалтын үр дүнд нийт 117 шүүгчийг томилсон байгаа.

Тэгээд хэрвээ бид цаашид Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа энэ онд дуусаж байгаа. Хэрвээ дараагийн ерөнхий зөвлөл өөр бодлого бариад, магадгүй шүүгчийн нөхөн бүрдүүлэлтийг байгаа ачаалалдаа тааруулаад, магадгүй шалгалтын бодлого, тэр нь зөөлөрч орж ирдэг ч юм уу, ямар нэгэн байдлаар хэрвээ бүрдүүлээд ирэх юм бол бид яг үнэхээр одоо яг энэ дараа оны төсөвт батлагдаж байгаа цалингийн 530 шүүгчээр ажиллах боломжгүй гэдгийг зориуд хэлмээр байна.

Гуравдугаарт, захиргааны ажилтны тухайд бидний тооцоогоор нийт 136... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд 1 минут өгье. Хариулъя.

Н.Мөнгөнцэцэг: 136 орон тоог цомхотгохоор байгаа. Гэтэл шүүгчээ дагаад шүүгч туслахтай байна. Нарийн бичигтэй байдаг. Гэтэл ажлын албаны бусад ажилтнууд гээд.

Тэгэхээр энэ бол хуулиар хүлээсэн байх ёстой тэр орон тоонууд байдаг. Өөрөөр хэлбэл хэн байна вэ гэхээр нягтлан, үйлчилгээний ажилтнууд, тэгээд эвлэрүүлэн зуучлагч туслахтайгаа. Ингээд бодохоор яалт ч үгүй орон тооны тухайд илүү ажиллаж байгаа гэсэн тоо үнэхээр байхгүй.

Тэгээд дээр нь бид хэд одоо яг ингээд тоог харахаар төрийн захиргааны албан хаагчаас хэрвээ туслахтайгааодоо ажиллаж байгаа шүүгчийг туслахтайгаа заавал байна гэдгээр тооцоход 20-ийг, төрийн үйлчилгээний бусад албан хаагчаас 82. ийм тооцоо байна гэдгийг зориуд хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Н.Мөнгөнцэцэг даргад. Л.Мөнхбаатар сайдын микрофоныг өгье.

Л.Мөнхбаатар: П.Сайнзориг гишүүн чухал асуудлыг хөндөж асууж байна.

Төсөвт хэмнэлт хийх гэсэн агуулгаар нь албан хаагчдын 9 хувийг цомхотгох асуудал тухайн салбарын байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах нөхцөлийг алдагдуулж байна уу гэсэн агуулгыг асууж байна.

Ер нь 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах буюу төсвийн тодотголоор сая манай салбарын хувьд мянган оронтой буюу 97.2 тэрбум төгрөгийн урсгал зардал хасагдсан. Хөрөнгө оруулалтын зардлаас 3.8 тэрбум төгрөгийн зардал хасагдсан. Нийтдээ 101.0 тэрбум төгрөгийн зардал хасагдаж батлагдсан байгаа юм.

Энэ мянган хувийн тоо гэдэг салбарын хувьд их том тоо. Гэхдээ төсөвт хэмнэлт хийх, эдийн засгийн нөхцөл байдалтайгаа уялдуулаад зайлшгүй ийм арга хэмжээ авсан.

Ийм учраас цаашид үүнээс... /минут дуусав/

Д.Цогтбаатар: 1 минут нэмж өгье. Тодруулаад хариулъя.

Л.Мөнхбаатар: Ингэхээр цаашид одоогийнхоо батлагдсан орон тоогоор салбарын хэмжээнд үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжийг бүрдүүлэхийн төлөө ажиллана гэдгийг П.Сайнзориг гишүүнд хэлье.

Гэхдээ Та бүхэн маань ойлгож байгаа. Шинээр ажлын байрууд шаардлагатай байна. Цагдаагийн байгууллагын хувьд ажиллах нормативын хувьд хүрэхгүй байж байдаг. Хар тамхитай тэмцэх алба гээд сая шинээр байгууллаа. Шинэ орон тоо шаардагдана. Дотоодын цэрэгт Засгийн газраас олон объектуудыг шинээр хамгаалалтад авах шийдвэрүүд гарсан. Үүнийгээ хэрэгжүүлэхэд бодит орон тоо шаардлагатай байдаг. Гэхдээ одоо батлагдсан орон тооныхоо хүрээнд хэрэгжүүлж ажиллана гэдгийг хэлье.

Энэ оны төсөв дээр 44 тэрбум төгрөгийн зардал хасагдаж байгаа. Ингээд энэ хүрээнд нь энэ байгууллага хэвийн үйл ажиллагаагаа явуулж ажиллана гэдгийг хэлье.

Д.Цогтбаатар: Л.Мөнхбаатар сайд баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд нь байна уу? Алга байна. /алх цохив/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

Хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Дараагийн асуудалдаа оръё.

**Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай,
Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хоёр дахь хэлэлцүүлэг,
Танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./**

Хоёрдугаар асуудал. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Түрүүн ер нь танилцуулсан хүмүүс л бүгд байж байгаа биз дээ. Энд яг манай салбараас орж байгаа юунуудаа бас танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Дээд шүүхээс Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, Улсын дээд шүүхийн ерөнхий нягтлан бодогч А.Эрдэнэцэц, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранбилэг, Шүүхийн сахилгын хорооноос Шүүхийн сахилгын хорооны дарга Ч.Ариунтуяа, Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал, Хүний эрхийн Үндэсний Комиссоос Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Д.Ёндонжамц, Хүний эрхийн Үндэсний Комиссын ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээжид, Авлигатай тэмцэх газраас Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, Авлигатай тэмцэх газрын ерөнхий нягтлан бодогч Т.Цэрмаа, Улсын ерөнхий прокурорын газраас Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Цагаатгах ажлыг удирдан

зохион байгуулах улсын комиссоос Цагаатгах ажлыг удирдан удирдан зохион байгуулах Улсын комиссын нарийн бичгийн дарга Ч.Цасчихэр, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын ажлын албаны дарга Л.Очирсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Гантуяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч Г.Базаргүр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч Б.Хатантуул, Цагдаагийн ерөнхий газраас Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч, бригадын генерал Д.Сүхболд, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны цагдаагийн хурандаа Д.Батчулуун, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Б.Батзориг, Хил хамгаалах ерөнхий газраас Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч, бригадын генерал Ж.Бямбасүрэн, Хил хамгаалах ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, ерөнхий нягтлан бодогч, хурандаа Ц.Чойжилсүрэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга, хурандаа А.Намсаманд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Санхүү, үйлдвэр хөрөнгө оруулалтын газрын дарга, хурандаа Т.Өнөртуяа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга, хошууч Б.Энх-Од, Улсын бүртгэлийн ерөнхий газраас Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Давааням, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Энхнаран, Шүүх шинжилгээний ерөнхий газраас Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Буянбат, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Санхүү, хангамжийн газрын дарга, цагдаагийн хурандаа Х.Саранчимэг, Гадаадын иргэн, харьяатын газраас Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга Ж.Солонго, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга М.Түвшинжаргал, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч Н.Уранчимэг, Архивын ерөнхий газраас Архивын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэндсүрэн, Архивын ерөнхий газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Лхамсүрэн, Мэдээлэл, шуурхай удирдлагын төв. Эндээс тус төвийн дарга, цагдаагийн хурандаа П.Энхбаяр, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн Захиргаа, удирдлагын газрын Санхүү, ар талын тасгийн дарга, цагдаагийн ахмад Н.Уянга, Дотоод хэргийн их сургууль. Дотоод хэргийн их сургуулийн захирал, бригадын генерал О.Зоригт, Дотоод хэргийн их сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Ч.Лхагважав, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгээс тус эмнэлгийн захирал, дэд хурандаа Н.Одонгуа, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн штабын дарга бөгөөд Инновац, хөгжлийн асуудал эрхэлсэн дэд захирал, хошууч Г.Бат-Эрдэнэ, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн Санхүү, хангамжийн албаны дарга, ахмад М.Мөнхбаяр, Хууль зүйн туслалцааны төв. Тус төвийн дарга

Л.Уянга, Хууль зүйн туслалцааны төвийн ахлах нягтлан бодогч Л.Болор-Эрдэнэ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын алба. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын албаны дарга Л.Нямгэрэл гэсэн бүрэлдэхүүнтэй салбарын төлөөлөл, ажлын хэсэг хуралдаанд хүрэлцэн ирсэн байна.

Хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т Байнгын хорооны хуралдаанд гишүүд тухайн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлж болно гэж заасан байдаг.

Монгол Улсын 2026 оны төсвийн төслүүдийн талаар асуулт асуух гишүүн байвал нэрсээ өгье. Алга байна.

Монгол Улсын төсвийн 2026 оны төсвийн төслүүдтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье. Асуулт дээр.

Тэгвэл Да.Цогтбаатар гишүүний микрофоныг өгье. Би уг нь түрүүн цаг өгсөн. Наад цагаа түр зогсоож байгаарай.

Ц.Сандаг-Очир гишүүн асуулт асууя гэж байна. Нэг удаа өгье. Гэхдээ хэдүүлээ. Тийм үү. Тэгвэл ингэе. Асуулт асуух гишүүдийн нэрсийг дахиад авъя.

Х.Баасанжаргал гишүүнээр тасаллаа шүү. Ирцээрээ байгаа юм байна. Х.Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Надад 4 асуулт байна.

Сайд бараг хариулах байх даа. Ихэнх дээр нь. Эхний асуулт.

Хөрөнгө оруулалтыг үзэхээр үргэлжлэх хөрөнгө оруулалт 19, шинэ хөрөнгө оруулалт 26 орж ирсэн байна. Яг хөрөнгө оруулалт дээр.

Энэ хөрөнгө оруулалтын эрэмбийг яаж тогтоосон юм бол гэдэг нэг асуулт. Тэгээд ялангуяа үргэлжлэх 19 дотор 2013 оноос хойш явж байгаа 2 барилга, байгууламж байна. Аль болох хуучин барилга, байгууламж, үргэлжилж байгаа хөрөнгө оруулалтуудаа дуусах бодлого барихгүй юм уу? Тэгээд шинэ 26-г эрэмбэлсэн шалтгаан нь ямар эрэмбээр энэ 26 зайлшгүй гэж орж ирсэн тийм шалгуур үзүүлэлт, эрэмбийн үзүүлэлт гэж байгаа юу гэж нэг асуулт.

Хоёрдугаар асуулт. Төсөвтэй дагалдаад байгууллагуудын ажлын шалгуур үзүүлэлт орж ирдэг. Манай хууль зүйн салбарын шалгуур үзүүлэлт яг үнэндээ бусад салбарын шалгуур үзүүлэлтээс хамгийн муу байсан нь манай хууль зүйн шалгуур үзүүлэлт. Хууль зүйн салбарын.

Бид ажлынхаа шалгуур үзүүлэлтээ зөв тогтоож ерөөсөө чаддаггүй юм байна. Манай Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдсан байгаа. Энэ шалгуур үзүүлэлтүүдийг өөрчлөхөөр, шинэчлэхээр гэсэн үг. Тэгээд бусад салбарынхантай хамт ярилцаад хуулийн салбарын шалгуур үзүүлэлтийг ярихаар бараг зарим шалгуур үзүүлэлтээр нь бүр үнэхээр нээрээ ичмээр юмнууд байна.

Тэгэхээр манай салбарын удирдлагууд шалгуур үзүүлэлтүүдийг бүгдээрээ нэг харвал яасан юм бэ? Жишээ нь, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шалгуур үзүүлэлтүүд дээр хийх ажлуудаа л бүгдийг нь бичсэн. Тэчнээн шинжилгээ, тэчнээн эдийн засгийн шинжилгээ, тэчнээн криминологи шинжилгээ гээд л. Цагдаагийн байгууллага бас яг адилхан. Зорилт дээр нь шалгуур үзүүлэлтээ тавьсан.

Тэгэхээр яг энэ асуудлуудаа манай хууль зүйн салбарынхан ер нь нэг бодлогоор салбарынхаа хэмжээнд шалгуур үзүүлэлтээ нэг анхаарах ёстой болсон байна.

Гуравдугаарт, Хүний эрхийн Үндэсний Комиссын төсөв маш анхаарал татаж байгаа. Хөрөнгө оруулалт нь 2 тэрбум төгрөгөөр буураад ороод ирсэн. Энэ асуудал яах вэ цаашид.

Хүний эрхийн Үндэсний Комиссын төсөв буураад ороод ирсэн. Комиссын төсвийг нэмээч гэж байгаа юм биш. Ядаж өмнөх оных нь хэмжээнд аваачих. Дээрээс нь хэрвээ энэ хөрөнгө оруулалтын төсөв буурвал ямар үр дагавар үүсэх вэ гэдэг дээр комисс бас хариулт хэлэх ёстой байх.

Хамгийн сүүлд манай салбарын нэг том ажил 2026 онд явагдана. Хүүхэд, гэр бүлийн шүүх байгуулагдана. Түүнтэй холбоотой төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв нь өөрөө яаж уялдаж байгаа вэ? Дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, судалгааныхан, Хууль зүйн яам бодлогоор энэ том шүүх, энэ том дагнасан шүүхийг бид бодлогоор ирэх оноос эхлээд авч явах ёстой. Тэгээд түүнтэй холбоотой төсөв зүйл ерөөсөө энэ дээр ялгаатай харагдахгүй байна. Энэ дээр ямар тайлбар байна вэ гээд ийм 4 асуулт байна.

Д.Цогтбаатар: Хууль зүйн сайдаас нэг асуулт нь байна. Хүний эрхийн комисстой холбоотой асуултыг хэнээс. Комисс өөрөө хариулаад явах уу? Тэгье.

Тэгэхээр энэ дөрвөн асуултаас Хууль зүйн сайд. Тэгье. Эхний хоёр асуултад Хууль зүйн сайд.

Л.Мөнхбаатар сайдын микрофоныг өгье.

Л.Мөнхбаатар: Х.Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

Хөрөнгө оруулалтын хувьд ирэх онд он дамжин шилжих барилга 9 байгаа. Энэ арга хэмжээнд 13.7 тэрбум төгрөг байгаа. Шинээр эхлэх барилга, байгууламжийн 12 төсөл байгаа. Энд 27.7 тэрбум төгрөгийн ажил байна.

Их засварт нэг буюу Хил хамгаалах ерөнхий газар дээр байгаа юм. 2 тэрбум 550.0 сая төгрөгийн асуудал байна.

Ингээд манай хөрөнгө оруулалтуудын хувьд ийм байгаа юм.

Эндээс шилжих барилгуудыг аль болохоор дуусгах бодлогыг барьж байгаа. Одоо энэ шилжих барилгууд, жагсаалттай нь гишүүн танилцсан байгаа. Энд нийтдээ нэр дурдагдсан 13.7 тэрбум төгрөгийн санхүүжилтээр асуудлууд үргэлжлээд явах байгаа юм.

Шинээр тусгагдсан хөрөнгө оруулалтыг хэрхэн яаж, хэрхэн эрэмблэж байгаа вэ гэж асууж байна. Мэдээж зураг төсөвтэй, Сангийн яамнаас тавьж байгаа шаардлагууд, PMS /Public Management System/ гээд тэр программд тавигдаж байгаа шаардлагууд. Мөн шивэгдээд орон нутгаасаа саналууд ирээд тодорхой эрэмбийг байгууллагаар нь өөрсдөөр нь мэдээж эрэмбэлүүлж ирүүлж байна.

Тэр тодорхой шаардлага, үндэслэлийг нь авч үзээд Хууль зүйн яам Сангийн яаманд хянуулан ийнхүү эрэмбийг тогтоож байгаа.

Энэ жилийн хувьд нийтдээ энэ чинь 93.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт байгаа юм. Хэдийгээр бага боловч үүнийг нь нэн шаардлагатай барилга, байгууламж дээр л тавьсан байгаа гэдгийг танд хэлье. Тоног төхөөрөмжийн хувьд ч гэсэн нэн шаардлагатай байгаа тоног төхөөрөмжүүдээ ангилаад тавьсан байгаа юм.

Шалгуурын хувьд таны хэлж байгаатай санал нэг байна. Хуулиар хүлээсэн зорилго, чиг үүрэгтэй уялдуулан хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулдаг. Салбарын хэмжээнд 60 шалгуур үзүүлэлтийг гарган ирүүлсэн.

Ингэхээр цаашид энэ чиглэлээр Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гарсан байгаа. Үүнтэй манай харьяа байгууллагын удирдлагууд хамтран ажиллаж, шалгуур үзүүлэлтүүдээ боловсронгуй болгох, илүү үнэлэхүйц хэмжээнд болох талд нь хамтран ажиллах нь зүйтэй гэж үзэж байгаа. Энэ чиглэлээр ажлын хэсэг болон тантай хамтран ажиллана гэдгээ хэлье.

Шилжих барилгуудын хувьд бүгд туссан байгаа гэдгийг бас хэлээдэхье.

Д.Цогтбаатар: Хүний эрхийн Үндэсний Комисс. Д.Сүнжид даргын микрофоныг өгье. Индэр дээрээс.

Д.Сүнжид: Хууль зүйн байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хүний эрхийн Үндэсний Комиссын урсгал зардлын төсөв 12.1 тэрбумаар 2025 онд батлагдсан байсан юм. Үүнээс одоо өргөн барьсан 2026 оны төсвийн төсөөлөл, төлөвлөгөөнд эндээс 2.6 тэрбум хасагдсан байгаа.

Урсгал зардлаас ингэж хасагдахаар нэгдүгээрт судалгаа, дүн шинжилгээ хийлгэх, бусдаар гүйцэтгүүлэх ажил, сургалт, нөлөөллийн ажил гэдэг дээр 1 тэрбумын зардал хасагдаж байгаа дүр зураг байна.

Тэгээд томилолтын зардлаас бас 300 сая орчим хасагдаж байгаа.

Эд хогшил, байрны түрээсийн зардал гээд өглөг үүсэхээр нөхцөл байдал үүсэж байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс 7 тухайн хуулиар хүлээсэн 20 төрлийн чиг үүрэг байдаг. Хэрвээ урсгал зардлаас 2.6-г хасах юм бол, 2025 оныхоос буурвал 3 төрлийн чиг үүрэгт нь бүрэн хэмжээнд хийж чадахгүй, доголдол үүсэхээр байгаа гэдгийг танилцуулъя.

25.1 тэрбумын хөрөнгө оруулалтын зардлыг Хууль зүйн байнгын хороогоор дэмжиж баталсан. Энэ зардал бас бүрэн хасагдсан байгаа.

Тэгэхээр урсгал зардлыг өмнөх буюу 2025 оны батлагдсан төсвөөс... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулъя. 1 минут өгье.

Д.Сүнжид: 2025 оны төсвөөс бууруулахгүй байж үйл ажиллагааг хэвийн гүйцэтгэнэ гэдэг энэ онцлогийг бас харгалзаж үзээсэй гэж хүсэж байна.

Энэ хяналт шалгалтын хүрээнд томилолтын зардал гэж байгаа юм л даа. Томилолтын зардал дээр бид яг тодорхой зарим хүний эрхийн зөрчил дээр, газар дээр нь ажиллах шаардлага гардаг.

Тэгэхээр энэ хяналт шалгалтыг хийх, зохион байгуулах зардал үүний цаана бас орсон явж байгаа. Энэ бүхнийг та бүхнийг, Хууль зүйн байнгын хорооны гишүүдээс харгалзаж үзэж шийдээсэй гэж хүсэж байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Тэгье. Х.Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Бид нарт өгсөн шинэ хөрөнгө оруулалтын барилга, тоног төхөөрөмж гээд бүгдийг нь нийлүүлээд төсөл гээд өгсөн төсөл дээр одоо жишээ нь Авлигатай тэмцэх газрын барилгын их засвар гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр эд нарыг л шинэ гээд орж ирэхээр нь гайхаад асуугаад байгаа байхгүй юу. Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гээд. Тэгээд Авлигатай тэмцэх газар гээд.

Дүүргүүдийн нэгдсэн прокурорын байр гээд 2013 онд эхлээд, одоо 2027 онд дуусна. Шүүхийнх бас 2013 онд эхлээд, 2027 онд дуусна гээд. Ингээд энэ олон жил дамнасан барилгуудын асуудлыг л илүү барихгүй юу гэж асуугаад байгаа гол асуулт нь тэр юм.

Сүүлд хэлсэн. Энэ дээр харин Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хариулах уу? Хамаарах уу, хамаарахгүй юу? Эсвэл хэн нь яах ёстой юм бол? Бид чинь хавар Хүний эрхийн Үндэсний Комисс болоод Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүхийн төсвийг хавар төсвийн төсөөллийг нь батлаад... /минут дуусав/

Д.Цогтбаатар: 3.Баасанням дарга. Сая танайтай холбогдсон асуулт. Энэ их засвар.

Урд нь хийгдэж байсан тэр ажлуудаа хийгээд явахгүй юм уу? Яагаад ямар шинэ ажлууд оруулаад ирсэн байгаа юм бэ гэдэг асуулт явж байна. Тийм.

Индрийн микрофон өгье.

3.Баасанням: Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга 3.Баасанням байна. Таны асуултад хариулъя.

Ирэх жилийн хувьд 230.0 сая төгрөг дээр их засвар гээд 2 барилгын дээврийн засварын ажил байгаа юм. Тэр 2 объектын. Нэг нь үндсэндээ 1964 онд ашиглалтад орсон барилга. Нөгөөдөх нь бас олон нийтийн төв гээд Стратеги судалгааны хүрээлэн байсан. Энэ хоёрын дээврийн засварын ажлыг сүүлийн 5, 8 жил ер нь засвар ороогүй юм. Тэгээд өнгөрсөн жилийн борооноор дээврээс нэлээн ус гоожоод засвар зайлшгүй хийх шаардлагатай байгаа юм.

Тэгээд ирэх жилийн төсөв дээр энэ засварын ажил тавигдсан байгаа. Дээврийн засварын ажил.

Д.Цогтбаатар: Н.Мөнгөнцэцэг дарга хариулах уу? Хүүхдийн асуудал эрхэлсэн шүүхийн асуудал. Дараа жил бид чинь байгуулна гээд явж байгаа шүү дээ.

Индэр дээрээс. Индэрийн микрофон өгье. Дараа нь прокурорынх бэлдэж байгаарай.

Н.Мөнгөнцэцэг: 2026 оны 01 сарын 01-нээс гэр бүл, хүүхдийн шүүх ажиллах ёстой.

Бэлтгэл ажлын хүрээнд бид ажлын хэсэг байгуулаад ямар ч л байсан бид бэлтгэл ажлын хүрээнд хангаад явж байгаа. Гэр бүлийн шүүхэд нийт 49 шүүгч, нийт 138 захиргааны ажилтан ажиллахаар төлөвлөсөн байгаа. Тэгээд цомхотголд оруулахгүйгээр нийт батлагдсан төсөв, урсгал зардлынхаа хүрээнд бид энэ хүмүүсийн орон тоо, цалинг оруулсан явж байгаа.

Бидний гол асуудал хууль тогтоомж, процессын хууль маань өөрөө батлагдаагүй байгаа.

Тэгэхээр гэр, бүл хүүхдийн шүүхийн харьяаллын асуудлыг шийдвэрлээд шүүн таслах ажиллагаа хэвийн явах бүрэн боломжтой. Бидний тухайд гэр, бүл хүүхдийн шүүхийн шүүгч... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулъя. Микрофон өгье. Индрийнхийг.

Н.Мөнгөнцэцэг: Гэр, бүл хүүхдийн шүүгчийн сонгон шалгаруулалтаа зарласан байгаа.

Мөн түүнчлэн шүүх байгуулахтай холбоотой байрны асуудал байгаа. Энэ байрны асуудлыг өөрсдийн дотоод нөөц бололцоондоо тулгуурлаад өөрсдийнхөө, магадгүй шүүх байгуулах асуудал 01 сарын 01-нээс хойшлогдож магадгүй гэсэн эрсдэлийг бас тооцоолоод бид өөрсдийнхөө боломжийг эрэлхийлээд өөрсдийн хуучин байрууддаа шүүхээ оруулна гэсэн төлөвлөгөөтэй явж байгаа.

Шууд түрээс гээд ярихаар өндөр зардал гарах учраас бид энд болгоомжтой хандаж байгаа гэдгийг бас зориуд хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Прокуророос хэн байна? Түрүүн Авлигатай тэмцэх газраас асуусан асуулт. Танайтай холбоотой.

С.Гансэлэм: Та бүхний өдрийн мэндийг эрье.

Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэмж байна. Гишүүний асуултад хариулъя.

Прокурорын байгууллага дээр 2013 оноос хойш удааширсан дүүргүүдийн нэгдсэн барилга гэсэн нэг барилга явж байгаа. 2013 оноос хойш үргэлжлээд явж байгаа барилга байгаа юм.

Энэ барилга дээр 2026 оны төсөв дээр 15 тэрбум төгрөгийн өртөг төсөвт суулгахаар санал өгсөн. Энэ маань дэмжигдээд явж байгаа. Гэхдээ 2013 оноос хойш маш удаашраад барилгууд явагдаж байгаа маань өөрөө төсөвт өртгүүд нь өсөөд, удаашраад маш хэцүү байдалд ордог учраас. Нийтдээ 40, 50 орчим тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй барилга байгаа юм.

Жил болгон ингэхээр бас л удаашраад байгаа учраас шүүх дээр ч, прокурор дээр ч явж байгаа энэ барилгуудын төсөвт өртгийг өшөө нэмэгдүүлж хурдан хугацаанд ашиглалтад оруулах зайлшгүй шаардлагатай гэсэн байр суурьтай байгаа. 2013 оноос хойш үргэлжилж байгаа барилга байгаа.

Прокурорын байгууллагын хэмжээнд гэхэд... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Микрофонд гүйцээгээд өгье. Гүйцээгээд хариулъя.

С.Гансэлэм: 1940 онд ашиглалтад орсон байртай явж байдаг.

Сүхбаатар дүүргийн прокурорын газар огт байр байхгүй. Сургалт, судалгааны хүрээлэнгийн байранд үйл ажиллагаа явуулж байдаг. Энэ мэтчилэнгээр прокурорын байгууллагын хэмжээнд хэдийгээр байр савны асуудлууд шийдэгдэж байгаа боловч бас бүрэн гүйцэж чадахгүй ийм төвөгтэй нөхцөл байдлууд зөндөө байна.

Чуулганы эхний асуудал дээр ч гэсэн прокурорын байгууллага дээр эхний хуралдаан дээр баахан барилга барьж байна гэсэн асуудлууд яригдаж байсан.

Тэгэхээр бид бүхэн албан үүргээ, үйл ажиллагаагаа явуулахын тулд зайлшгүй барихаас өөр, орох байргүй прокурорын газар нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа нөхцөл байдлууд байгаа гэдгийг хэлье.

Тэгээд дүүргүүдийн нэгдсэн прокурорын барилга 2013 оноос хойш 12, 13 жил үргэлжилж байгаа барилга байгаа учраас үүнийг хурдан хугацаанд ашиглалтад оруулах, төсөвт өртгийг нэмж тавиад хурдан хугацаанд ашиглалтад оруулах тал дээр бас анхаарч өгнө үү гэж Та бүхнээс хүсэж байна.

Д.Цогтбаатар: Ер нь манай салбарын, ялангуяа шүүхийн тухай хуулиар шүүхийн төсвийг Хууль зүйн байнгын хорооноос хянасан тэрийг буулгаж болохгүй гээд хуулийн заалттай байгаа. Үүнтэй холбогдсон асуудлаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хариулт өгье. Х.Баасанжаргал гишүүний асуултад.

Яагаад үүнийг зөрчөөд бууруулаад байгаа юм бэ? Наадах чинь яагаад гэвэл жинхэнээсээ хууль зөрчөөд байгаа байхгүй юу. Индэр дээр гараад хариулъя.

А.Энхбат: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн.

Бид хуулиар 3 дугаар сарын 15-нд 2026 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг боловсруулж гаргадаг.

Тэгэхдээ энэ дээр үндсэндээ нөгөө 9 үзүүлэлтээрээ, тэр дотроо төсвийн урсгал зарлага, урсгал тэнцэл гэдэг ч юм уу, макро үндсэн үзүүлэлтүүдээр бид тооцоо хийж явдаг.

Тэр хязгаарынх нь хүрээнд буюу макро эдийн засгийн өсөлт, инфляцын түвшин гэдэг ч юм уу энэ байдлаар нь бид явдаг болохоос биш одоо яг ингээд төсвийн ерөнхийлөн захирагч бүрийнх нь төсвийн урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал. Яг ийм байдлаар байх ёстой гэсэн тийм тооцоолол бид гаргадаггүй. Тэр хүрээндээ бид зөвхөн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төсөөллийг гаргаж Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд хүргүүлдэг ийм хуулийн заалттай байгаа.

Зүгээр яг энэ дээр нэмэлт мэдээлэл өгөхөд өнөөдөр Сангийн яамны мэдээлэл... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулъя. Индэрийн микрофон.

А.Энхбат: Сангийн яамны мэдээлж байгаагаар 208 хууль тогтоомжид төсөвтэй холбоотой заалтууд байдаг.

Салбар бүрийн өөрийнх нь төсөвтэй холбоотой амбицууд гарч ирдэг. Татвар төлөгчдийн мөнгөөр тэр бүх хуулийн заалтуудыг хэрэгжүүлнэ гэхээр үнэхээр бэрхшээл хүндрэл байгаа. Энэ дээр нэмэлт тодруулга тусгайлаад Сангийн яам хариулах байх гэж харж байна.

Д.Цогтбаатар: А.Энхбат дарга аа, сая та амбицууд гэж. Хууль зүйн байнгын хороо ямар нэгэн амбиц гаргаагүй. Энэ чинь хууль хэрэгжүүлж байгаа.

Тийм учраас бусад байгууллага нь амбиц байдаг юм байгаа биз. Бид энд хууль ярьж байгаа шүү. Та наадахаа бодож ярина шүү.

Сангийн яамныхан саяын асуултад хариулмаар байна. Энэ удаа дараа гарч байгаа учраас бид энэ дээр тодорхой хариулт Хууль зүйн байнгын хороо авмаар байна.

Индрийн микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам. М.Санжаадорж. Асуултад хариулъя.

Сангийн яамны хувьд төсвийг төлөвлөх процесс маань оны эхнээс эхэлдэг. Сая Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс макро эдийн засгийн тооцоолол ирснээс хойш төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө. Үүний дараа төсвийн ерөнхийлөн захирагчтай хязгаар батлагддаг. Тэгээд жилийн төсөв орж ирж байдаг.

9 хувиар жишээ нь орон тоо цомхотгох асуудал Улсын Их Хурал дээр батлагдсан. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө дээр байсан. Тэр дагуу бид оруулж ирсэн. Тэгээд байгаа төсөвтөө л багтааж оруулж ирж байгаа.

Түүнээс биш бүх газар бид байгаа төсвөөр орлогын хэмжээнээсээ нэмэгдүүлж тавих боломж байгаагүй.

Нэг талдаа бид статистик өөрчлөлтөөр 1 их наяд төгрөгийн зардал нэмэх шаардлагатай болсон. Ахмадын тэтгэвэр, тэтгэмж нэмэх гэх мэт зардлаар. Нөгөө талдаа нэмэх боломж маань 585.0 тэрбум төгрөг байсан.

Тэгэхээр зөрүүлээд... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Ер нь тэгэхдээ Х.Баасанжаргал гишүүн ээ, энэ дээр ингээд хасаад орж ирж байгаа ч гэсэн сая эдний өгөх хариулт нь тодорхой л доо. Нөгөө хөнжлийн хэмжээ хэрээрээ л гэдэг юм ярина шүү дээ.

Гэтэл тэр хөнжил зөндөө өөр газраас хэрэггүй гэж үзэж болохуйц зөндөө зардлын асуудал явж байгаа шүү дээ.

Тийм учраас хэлэлцүүлгийн явцад өөрийнхөө байр суурийг илэрхийлэх, зарчмын зөрүүтэй санал гаргах боломжууд нээлттэй байгааг Х.Баасанжаргал гишүүнд дурдаад хэлмээр байна.

Ц.Сандаг-Очир гишүүнд микрофон өгье. Таны нэр чинь байхгүй байна шүү дээ.

С.Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье. Энэ яагаад нэрс алга болоод байна?

С.Эрдэнэболд: Баярлалаа.

Яах вэ, агуулгын хувьд бол Х.Баасанжаргал гишүүнийхтэй төстэй. Тэгэхдээ ийм байгаа юм. Гол нь Хууль зүйн сайд руу чиглэж асууж байгаа юм.

Засгийн газар байгуулагдаад мөрийн хөтөлбөр Их Хурлаар батлаад, тэгээд манай Засгийн газар 578 зүйл, заалттай мөрийн хөтөлбөр нь нийтдээ 11 хэмжих нэгжээр 4 жилийн хугацаанд ийм ийм үр дүнд хүрнэ гэж зорилт тавьсан байхгүй юу. Одоо жишээлбэл авлигын индексийг 114-ийг тэд рүү оруулна, хүний хөгжлийн индексийг ингэж ахиулна гээд.

Энэ дотроо шударга ёсыг тогтоох, хууль хэрэгжих орчин нөхцөлийг сайжруулахтай холбоотой зорилт байгаа.

Мэдээж манай Байнгын хорооны хүрээний байгууллагуудын төсөв ярьж байгаа ч гэсэн илүү Хууль зүй, дотоод хэргийн яам буюу Засгийн газрын яг энэ

хууль хэрэгжүүлэх байгууллагын чиглэлд асуухад. Яах вэ, бид төсөв гэхээр л урсгал зардал, мэдээж цалин гээд л тогтмол гарах ёстой зардлууд маш их ярьж байгаа. Гэнгүүтээ дийлэнх нь баригдсан, дутуу орхисон барилга, тэрний мөнгийг гүйцээх гээд аж ахуйн шинж чанартай юмнууд маш их яригдаад явчхаж байгаа. Үүнийг ойлгож байна. Тэгээд байгууллага болгон манай энэ төсвийг дэмжээч, зарчмын зөрүүтэй санал гаргаач, ингээд өгөөч, тэгээд өгөөч гээд.

Тэгээд яах вэ, ер нь Хууль зүйн байнгын хорооны лав өнгөрсөн бүтэн жилийн явж ирсэн уур амьсгал бол аль болохоор хуулийн салбарынхаа байгууллагуудыг эхийг нь эцээж, тугалыг нь тураахгүй ажлаа нэг аятайхан хийчих энэ боломжийг нь хангая гэдэг байр сууриас л яваад байгаа.

Тэгэхээр хэмжигдэх нэгж дээрээ очоод төсвүүд жишээлбэл хасагдаж танагдахаар нөгөө хүний эрхийн зөрчил гарах магадлал, дээрээс нь хууль хэрэгжих процесс доголдох байдал ч гэдэг юм уу энд яаж нөлөөлөөд байгаа гэдэг дээр нэг ийм симуляц судалгаа ч юм уу, тийм юм байдаг бол уг нь амар байгаа байхгүй юу.

Жишээлбэл, одоо тэнд орон тооны асуудлууд яригдахад, орон тоо дутахад, эсвэл 461 дүгээр анги дээр очоод ярихад гурав, дөрвөн хүний хийх ажил дээр 2 харгалзагч тулаа хийгээд тэр хүний зан харилцааны асуудал. Цаашаагаа том асуудлууд үүсээд байгаа юм л даа гэдэг шиг яг энэ төсөв чинь яагаад LAW ENFORCEMENT буюу хууль хэрэгжүүлэх чанартай шууд нөлөөлөөд байгаа гэдэг дээр Эдийн засаг, хөгжлийн яам ч юм уу ер нь энэ дээр нэг ийм судалгаанууд хуулийн яамтайгаа хамтарч байгаад хийдэг бол уг нь амархан байгаа юм.

Тэгэхгүй болохоор цаашдаа ямар зүй тогтол харагдаад байна гэхээр нэг ийм гуйсан, түүсэн, лоббидсон тийм байж болохгүй шүү дээ. Тийм ээ. Энэ дээр Хууль зүйн сайд жишээлбэл яг энэ гарцаагүй төсвүүдийг яагаад авч үлдэх ёстой. Бусад байгууллагууд ч гэсэн энэ дээрээ бас яг ийм тодорхой баримттай, үндэслэлтэй, судалгаатай юм хэлж байвал бид нарт амар байгаа юм.

Д.Цогтбаатар: Хууль зүйн сайдын микрофоныг өгье. Л.Мөнхбаатар гишүүний микрофон.

Л.Мөнхбаатар: С.Эрдэнэболд гишүүний хөндөж байгаа асуудал мэдээж чухал зүйл.

Мэдээж төсөв гэдэг маань хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхүйц, түүнийг хангахуйц хэмжээнд л байх ёстой. Мэдээж таны ярьдаг хүний эрхийг хангах, нийгэмд хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардагдах ийм л төсвүүдийг батлах гэж хичээж байгаа.

Барилга, байгууламж дээр төвлөрсөн байна гэдэг. Энэ бас л төрийн үйлчилгээ үзүүлэх, ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй

холбоотой л ийм асуудлууд нь түлхүү орж ирж байгаа харагдаж байгаа байх. Гэхдээ энэ дотор бас тоног төхөөрөмж болоод урсгал зардал дээр явж байгаа олон асуудлууд нь энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх хэмжээнд зарцуулагдах ёстой. Гэхдээ хангалттай хэмжээнд биш байж магадгүй.

Гэхдээ ер нь цаашдаа ингэмээр юм билээ. Яг сая таны ярьж байгаа энэ зүйлийг үндсээр нь авч үзэхгүй бол төсөв дээр яриад л, төсөв дээр гишүүдээр гуйлгаад гэдэг юм уу, дэмжүүлээд л. Хууль зүйн байнгын хороо үеийн үед л дэмжиж ирсэн. Энэ хэмжээнд яваад байх биш энэ бүгдийг цогцоор нь авч үзэх шаардлагатай байгаа юм. Энэ бол салбарынхаа байгууллагуудыг, бүх байгууллагуудыг процессын дахин инженерчлэл хийе гэж бодож байгаа.

Эхнийх нь цагдаагийн байгууллага сая хийгдээд дуусаж байна. Энд яг саяын таны хэлж байгаа тэр ажлын ачаалал, хууль эрх зүйн хувьд ямар зөрчилтэй хийдэлтэй зүйлүүд байгаа юм. Ажлын ачааллын хувьд яах юм. Чиг үүргийн давхцалаа яаж арилгах юм. Шинэ дижитал буюу шинэ инновацад суурилсан ямар бүтээгдэхүүнүүд хийж байж тэр үр дүн гаргах юм гээд энэ зүйлүүд дээр нь бүх харьяа байгууллага дээрээ хийсний үндсэн дээр төсөв маань илүү үр дүнтэй бодитой болно гэж үзэж байгаа юм.

Тийм учраас цагдаагийн байгууллагаас сая хийгээд дууссан. Одоо ингээд цаашдаа Хууль зүй, дотоод хэргийн сайдын хүрээний бүх байгууллагуудад процессын дахин эмчлэлийг хийнэ. Үүнийх нь үндсэн дээр төсөв маань илүү тодорхой, үр дүнтэй иргэд болоод хүсэн хүлээсэн хангахуйц хэмжээнд орж ирнэ гэж үзэж байгаа гэдгээ танд хэлье.

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Би Байнгын хорооны дарга болоод зөвлөхөөс нэг асуулт асууя.

Манай эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас ирэх жилийн төсөвтэй холбогдуулж төсөв, хөрөнгө ингэлээ, хөрөнгө оруулалт ингэлээ гэсэн ийм бичиг ирсэн байгаа юу? Мэдээж бүгд 100 хувь бүрэн дүүрэн гэж хэлж чадахгүй. Төсөв, санхүү хүндрэлтэй байгаа нөхцөлд бүх л салбарын байгууллагуудын төсөв хасагдсан байгаа.

Гэхдээ бид өнгөрсөн хугацаанд Хууль зүйн байнгын хороо эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсвийг хасуулахгүй байх, өргөн барьснаар нь батлах гэдэг юм уу хуулийн зохицуулалтыг хийсэн. Үүнтэй холбогдуулаад эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас ийм санал, гомдол ирсэн, санал, хүсэлт ирсэн зүйл байна уу гэдгийг нэгд асууя.

Хоёрт, ирэх жил төрийн албан хаагчдын 9 хувийн цомхотгол эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд дээр яаж тусаж байгаа вэ? Байгууллагын

дарга нар 9 хувийн цомхотголыг яаж хийх гэж байна вэ? Яаж хийж байгаа вэ? Цагдаагийн ерөнхий газрын дарга, шүүх, прокурор, Хүний эрхийн Үндэсний Комисс гэх мэт гол гол байгууллагууд маань 9 хувийн цомхотголыг яаж хийх гэж байгаа юм.

Ингэснээр байгууллагын хэвийн үйл ажиллагаанд яаж сөргөөр нөлөөлөх гэж байгаа вэ гэдгийг асууя.

Нөгөө талаар өнгөрсөн 2000-2024 оны Улсын Их Хурал, Хууль зүйн байнгын хороо энэ салбарын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсөв санхүү дээр асар их анхаарсан шүү. Асар сайн дэмжиж өгсөн шүү. Тэр битгий хэл Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсвийг хасахгүй байх, өргөн барьснаар нь баталдаг байх хүртэл хуулийн зохицуулалтыг хийж өгч байсан.

Ингээд Та бүхний бүтэц, орон тоо, зардал юмыг нэмэгдүүлж өгсөн. Шүүхийн ерөнхий зөвлөл дээр гэхэд сүүлийн 10 гаруй жил хөрөнгө оруулалт “0” байсныг бид яаж нэмэгдүүлж өгч байлаа. /минут дуусав/

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг гүйцээж өгье.

Ц.Сандаг-Очир: Тэглээ гээд үйл ажиллагаа, үр дүн, бүтээмж яривал ямар байгаа вэ?

Та бүхний ирэх жилийн батлагдах төсвийг үүгээр баталлаа гэхэд үйл ажиллагааны бүтээмж, үр дүнтэй хэрхэн яаж холбогдож байгаа юм?

- ▶ Яаж бүтээмж гарах юм?
- ▶ Яаж үр дүн гарах юм?
- ▶ Яаж авлигатай тэмцэх юм?
- ▶ Яаж гэмт хэрэгтэй тэмцэх юм?
- ▶ Шударга ёсыг яаж тогтоох юм

гээд энэ талаас нь төсөвтэйгөө холбогдвол ер нь хэр үр дүн гарахаар төсөв бэ?

Сангийн яам ер нь энэ талаас нь энэ байгууллагуудын төсвийг яаж хянаж байгаа вэ?

Энэ хэмжээний төсөв өгөхөд ирэх жил гэмт хэрэгтэй тэмцэх ажилд, шударга ёсны дэнс болсон шүүхийн салбарт, хүний эрхийн асуудалд ямар үр дүн гарна гэж төсвийг нь хянаж нягталж... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Таныхыг шууд ахиад 1 минутыг өгчихье. Ингээд 3 минут 1, 1 юугаар өгчихье.

Ц.Сандаг-Очир: Тэгээд тийм үндсэндээ асуулаа.

Тэгээд Сангийн яам энэ байгууллагуудын төсвийг хасахдаа их сайн.

- Хаслаа хаслаа гэхэд юун дээр үндэслэж хасаж байна вэ?
- Бүтээмж, үр дүнтэй нь яаж уялдуулж байна вэ?
- Хэрхэн яаж үр дүн гарна гэж тооцсон бэ?

Тэр талаасаа асуудлыг яаж харж байна вэ? Энэ дээр та бүхэн хэлээд.

Тэгэхгүй бол бид олон жил ярилаа. Жил болгон л төсөв баталдаг. Тэгээд л орж ирсэн саналынх нь хүрээнд гэдэг юм уу, эсвэл хоёр, гурван тэрбумаар бууруулаад батлаад л өгдөг. Цаана нь үр дүн гарахгүй байна шүү дээ.

- Нийгэмд ард иргэд уур бухимдал ихтэй байна.
- Шударга ёсны асуудал тогтож өгөхгүй байна. Хүсэж байна.
- Шүүхийн асуудал ямар байна.
- Шүүгч нарын асуудал ямар байна.
- Прокуроруудын асуудал ямар байна.
- Хүний эрхтэй яаж тэмцэж байна.

Үр дүн гарч байна уу, үгүй юу гээд яривал.

Үүний цаана дандаа эдийн засгийн асуудал, дандаа төсөв, санхүүгийн асуудал байгаа.

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүн ээ, таны цаг зогссон байна шүү. Тийм.

Сүүлдээ Байнгын хорооны даргын эрх мэдлийг эдэлсэн сууж байх шиг байна.

Ингэе. Хамгийн эхний асуулт Байнгын хорооны даргаас байсан.

Тэгэхээр манайд бичгүүд ирсэн. Яах аргагүй төсвийн асуудал яригдаад ирэнгүүт мэдээж хасагдаж байгаа юман дээр чинь байгууллагууд өөрийнхөө байр суурийг илэрхийлнэ шүү дээ.

Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооноос, тэгээд Хүний эрхийн Үндэсний Комиссоос төсөвтэй холбогдсон хүсэлтүүд ирсэн байгаа.

Бид үүнийг нь зохих журмынх нь дагуу хэлэлцэх, зарчмын зөрүүтэй санал энэ тэр гаргах юман дээр нь энэ асуудлуудыг нь гаргаж тавина.

Зүгээр мэдээлэхэд Шүүхийн ерөнхий зөвлөлийн хөрөнгө оруулалтын төсвөөс 260.0 тэрбумыг аваачаад хассан байж байгаа юм. Сахилгын хорооноос бас нэлээн хассан. Хүний эрхийн комиссоос 25 тэрбум хөрөнгө оруулалтаас нь хассан ийм нөхцөлүүд байгаа.

Энэ дээр тэгэхээр Байнгын хорооны гишүүд хэдүүлээ ярьж байгаад энэ дээр бас өөрсдийнхөө байр суурийг хэлж, яг нөгөө хэлэлцэх шатдаа энэ асуудал ярьж явна.

Дараагийн асуулт нь хэнээс. Тийм. 9 хувийн цомхотгол. Цагдаагийн ерөнхий газраас асууж байсан. Тэгээд прокурор, хилийн цэргийн газар энэ дээр та нар ер нь 9 хувийн цомхотгол дээр. Яг үнэн. Шүүх. Тус тусдаа хариулчих. Индэр дээр гараад хариулна.

Тэгэхээр Цагдаагийн ерөнхий газраас эхэлье. Индэр дээр микрофон өгье.

Т.Сүхболд: Та бүхний амрыг эрье. Цагдаагийн ерөнхий газар.

Цагдаагийн байгууллага, дотоодын цэргийн байгууллагаас 9 хувь орон тоо хассан. Тэгээд бид ер нь бүх л нэгжүүдээсээ хассан.

Хамгийн гол нь гудамжинд үүрэг гүйцэтгэж байгаа эргүүлийн цагдаа, хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагчаас хасагдаагүй. Мөрдөн шалгах чиглэлээр ажиллаж байгаа хүний эрхтэй холбоотой. Дээрээс нь мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулах чиглэлээр ажиллаж байгаа алба хаагчдаасаа хасаагүй.

Бусад цагдаа, жолооч, захиргааны ажилтан, хамгаалалтын ажилтан гээд бүх нэгжүүдээсээ л яг 9 хувиар хассан байгаа.

9 хувиар хасаад бид ажил үүргээ ямар ч байсан хэвийн гүйцэтгэж байгаа. Гэтэл бид нарт 2026 онд Засгийн газрын тогтоолтой, мөн шинээр бий болж байгаа шүүхүүдтэй холбоотой орон тоонууд бас бий болсн... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Микрофон нэмээд өгье. 1 минут.

Т.Сүхболд: Засгийн газрын тогтоолоор батлагдсан гэр бүлийн шүүхтэй холбоотой орон тоо зайлшгүй нэмэгдэхээр байгаа.

Дээрээс нь, Эрдэнэбүрэнгийн цахилгаан станц 04 сарын 01-ний өдрөөс ашиглалтад орно.

Гэр бүлийн шүүх 01 сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулна.

Дээрээс нь, хамгаалалт болон зарим аймгуудын усны хамгаалалтыг ав гэсэн Засгийн газрын тогтоол гарсан. Яг үүнтэй холбогдуулаад бид нарт 843 орон тоо хэрэгтэй байгаа.

Хэрвээ энэ 843 орон тоо батлагдахгүй бол бид 2026 онд Засгийн газрын тогтоолоор баталсан усны эх үүсвэрүүд, Эрдэнэбүрэний цахилгаан станц, дээрээс нь гэр бүлийн шүүхтэй холбоотой ямар ч хамгаалалт, зохицуулалт хийх боломжгүй байгаа. Яг орон тоо нэмж батлагдахгүй л бол. Ийм байгаа.

Д.Цогтбаатар: Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Н.Мөнгөнцэцэг дарга.

Н.Мөнгөнцэцэг: Өмнөх 2024 оны төсөвт бидэнд яах аргагүй хөрөнгө оруулалт дээр 60.0 тэрбумын барилга, байшингийн төсөв тусгагдсан. Бид 5 газар барилгын ажлаа эхлүүлсэн явж байгаа.

Энэ оны төсөв дээр шинээр хөрөнгө оруулалт тавиагүй. Харин 2025 онд хийж хэрэгжүүлж эхэлсэн барилга дээр яалт ч үгүй үргэлжлүүлэхээр төсөв тавигдсан байгаа.

Харин Хан-Уул дүүрэгт байрлах нэгдсэн шүүхүүдийн байрны цогцолбор дээр энэ барилгыг 3 жил дараалан барихаар тавьсан байгаа.

Гэтэл энэ жил ингээд барилгын нийт каркас босголт бэлэн болоод дараа жил дотор засал руу орох бүрэн боломжтой байгаа учраас бидний хувьд гаргаж байгаа санал дараа жилдээ багтаагаад нийт үлдсэн төсвийг тавиад өгөөч ээ гэсэн байгаа.

Хоёрдугаарт, сая... /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 1 минут нэмж өгье.

Н.Мөнгөнцэцэг: 2024 онд баталсан шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого дээр бид үйл ажиллагаа, зорилтыг үр дүнгээр нь ямар байхаар шалгуур үзүүлэлтүүдээ тавьж өгсөн байгаа.

Үүнтэй холбоотойгоор 2023 онтой харьцуулаад ямар үр дүн гарсан юм бэ гэж.

Тэгэхээр шүүхийн гол бүтээгдэхүүн юу вэ гэхээр шүүн таслах ажиллагаа байгаа. Шүүн таслах ажиллагааг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэх.

Өмнөх онд 79 хувийн хуульд заасан хугацаанд шийдвэрлэдэг байсан бол энэ онд бидний гаргасан дүнгээр 81 хувиар хуульд заасан хугацаандаа хэргийг хянан шийдвэрлэсэн байна.

Мөн түүнчлэн бас нэг гол үзүүлэлт бол анхан шатын шүүхийн шийдвэрт хэчнээн хэрэгт нь гомдол гаргаж байна гээд.

Тэгэхээр 2023 онд 7.6 хувьд нь гомдол гарч байсан бол энэ онд 7 хувьд нь гомдол гарсан. Ийм сайжирсан үзүүлэлт байгаа гэдгийг бас зориуд хэлмээр байна.

Хоёрдугаарт, өмнө хэлсэнчлэн шинэ хөрөнгө оруулалт тавиагүй гэдэг дээр... /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Прокуророос. Дараа нь Авлигатай тэмцэх газар бэлдэж байгаарай. Дараа нь Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн.

С.Гансэлэм: Улсын ерөнхий прокурорын газраас С.Гансэлэм хариулъя.

Төсөв дээр ялгаагүй нийт 9 хувийн хасагдал прокурорын байгууллага дээр мөн орж ирсэн.

Тэгэхээр прокурорууд маань улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар 709 прокурор л улсын хэмжээний үйл ажиллагаа явуулдаг. 793 ажилтан. Ингээд нийт 1502 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулдаг байгууллага.

Тэгэхээр үүнээс 9 хувиар хасагдана гэхээр нийт 132 орон тоо хасагдаж байгаа юм.

Тэгэхээр прокурорууд өнөөдөр ажлын бид 5 өдөртэй байдаг бол үнэхээр 6 өдөр сууж нэг өдөр нь заавал илүү ажиллахгүй бол ажлаа багтааж амждаггүй. Ажлын 6 өдөртэй.

Өдрийн ажлын үргэлжлэх цаг 8 хуулиараа байдаг бол бид 10-аас 12 цаг сууж байж тухайн өдрийнхөө бас нэг тодорхой хэмжээний ажлуудыг нугалдаг ийм ажил ачаалалтай ажилладаг. 709-хөн прокурорын хувьд улсын хэмжээний.

Тэгэхэд үүнээс 9 хувиар хасагдахаар үнэхээр үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй нөхцөл байдлууд үүсэж байгааг Та бүхэн анхаарч үзэх шаардлагатай гэж үзэж байна.

Мөн гэр бүлийн шүүх байгуулагдаад шүүгч нар... /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 1 минут.

С.Гансэлэм: Холбогдуулаад бас прокуроруудыг мэргэшүүлэх, прокуроруудыг тодорхой үйл ажиллагаа явуулахын тулд томилох шаардлагууд байгаа учраас мөн энэ хууль батлагдсантай холбогдуулаад нэмэх байхад харин ингээд хасагдаад байхаар үйл ажиллагаа явуулахад үнэхээрийн хүндрэлтэй зүйлүүд байгаа гэдгийг Та бүхэн бас анхаарч өгөөч ээ гэсэн хүсэлттэй байна.

Барилга, байгууллагын тэр нэг зүйл хэлэхэд улсын хэмжээнд барилга байхгүй газар Говь-Алтай аймаг, Орхон, Баянзүрх дүүрэг 1940 онд ашиглалтад орсон, ийм аж ахуйн аргаар барьсан барилгатай. Үнэхээрийн нөхцөлүүд хэцүү байдаг. Энэ дээр тодорхой хэмжээний нэмэх хүсэлтийг хүргүүлж байгаа. Үүнийг Та бүхэн үзэх боломж байдаг бол үүнийг харгалзаж үзээч ээ гэсэн нэг ийм саналууд хэлье.

Ц.Сандаг-Очир: Авлигатай тэмцэх газар. Дараа нь Шүүх шинжилгээ ерөнхий газар. Тэгээд Хил хамгаалах газар бэлдэж байгаарай.

З.Баасанням: Орон тооны 9 хувийн хэмнэлт бусад байгууллагатай ижил хүндрэл бий болгож байгаа.

Гэхдээ энэ дээр нэгэнт батлагдсан төсвийнхөө хүрээнд үүнийг зохицуулаад л ажиллахаас өөр аргагүй байдалд байна. Гэхдээ жирэмсний болон сургалтын чөлөөтэй алба хаагчдынхаа оронд нөхөн томилгоо хийхгүй байх, шинээр албан хаагч томилохгүй байх, энэ дээрээ захиргааны болон аж ахуйн албаны чиглэл дээр байгаа орон тоон дээр томилгоо хийхгүй байхаар зохицуулалт авахаар төлөвлөж байна.

Тэгээд мөн илүү цагаар ажиллах ажлын ачаалал энэ хэвээрээ бусад албан хаагч дээр нэмэгдэж, ачаалал ихсэх төлөвтэй байгаа. Хүндрэл энэ хэрээрээ гарч ирэхийг үгүйсгэхээргүй байгаа.

Д.Цогтбаатар: Одоо Хил хамгаалах газрын дарга Ж.Бямбасүрэн генерал.

Ж.Бямбасүрэн: Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Ж.Бямбасүрэн илтгэж байна.

9 хувийн хэмнэлтийн хувьд Хил хамгаалах байгууллага батлагдсан төсөвтөө багтаад зохицуулна. Тэгэхдээ энэ дээр томилогдоогүй байгаа орон тоонуудыг зогсоож, дахиад энэ жил тэтгэвэрт гарч байгаа, чөлөөлөгдөж байгаа улсуудынхаа оронд хүнд томилохгүй байх замаар зохицуулалтуудыг хийнэ.

Мөн энэ жил болон ирэх жил хэрэгжүүлэх хил хамгаалалтад нэвтрүүлж байгаа техник, технологийн үр дүнд бид хүний хүчийг хэмнэнэ гэсэн тооцоололтойгоор ирэх оны төсөвтөө багтааж ажлаа зохицуулна гэж бодож байгаа.

Ирэх онд хүндэрч болзошгүй асуудлууд бол албан хаагчдын 5 жилийн урамшуулал, 36 сарын тэтгэмжийн асуудал хүндрэл учруулж болзошгүй байгаа. Тэгээд энэ бол бас албаны үр дүн, албан хаагчдын нөхөн хангалтад сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзэж байгааг илтгэе. Илтгэж дууслаа.

Д.Цогтбаатар: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар.

Сангийн яам энэ дээр хариулах уу? Сангийн яам хаана байна?

М.Санжаадорж: Сангийн яам. М.Санжаадорж асуултад хариулъя.

9 хувийн цомхотголын асуудлыг уг нь логикийн хувьд яаж явах ёстой вэ гэхээр чиг үүргийн шинжилгээ хийгээд, тухайн байгууллагын гол чиг үүргүүдээ тогтоож аваад, үүн дээрээсээ нэгдүгээрт хувийн хэвшилд шилжүүлэх боломжтой чиг үүрэг. Мөн дээрээс нь хасах боломжтой, нягтруулах боломжтой чиг үүргүүдээ гаргаж ирээд, тэр чиг үүргийнхээ хүрээндээ энэ цомхотголыг хийхийг Засгийн газрын Хэрэг эрхлэхээс бүх төсвийн ерөнхий захирагч нарт чиглэл өгсөн байгаа.

Гэхдээ саяын тайлбарлаж байгаа шиг энэ удаадаа нэлээн тулгамдан орсон учраас чиг үүргийн шинжилгээгээ хийсэн байгууллагууд ховор байна лээ.

Тэгээд хийгээгүй учраас байгууллагууд яаж байна гэхээр тэтгэвэрт гарсан хүний оронд орон тоонд нь хүн авахгүй байхаар ч юм уу, ийм байдлаар явж байгаа.

Сангийн яамны хувьд төсвийн ерөнхийлөн захирагчид ямар боломж олгож байгаа гэхээр нэгдүгээрт яам, агентлагийн төв аппарат нь заавал 9 хувийг нь цомхотгох гэдэг асуудал. Түүнээсээ доошоо нийт 9 хувийн цомхотголын нийт орон тоогоо барь гэдэг ийм л зохицуулалтын боломж олгож байгаа.

Өөрөөр хэлбэл жишээ нь аль нэг аймгийнх нь хэрэгцээ шаардлага өндөр байх юм бол тэндээ хас... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Танайх яаж хийх вэ? 9 хувийн цомхотголоо яаж хийхээр байна? Ер нь ямар бэрхшээл учирч байна? Тийм асуулт байсан юм. Та хариулах уу? Индэрт дээр. Индрийн микрофон өгье.

А.Намсаманд: Шүүхийн шийдвэр ерөнхий газрын Тэргүүн дэд дарга, хурандаа А.Намсанд.

9 хувийн манай байгууллага зарим орон тооны чиг үүргийн давхардал байсан орон тоон дээрээ бас ажилласан байж байгаа.

Д.Цогтбаатар: Асуулт нь, ер нь танайд хэр хүндрэл учрахаар. Яагаад гэвэл танайд яг энэ эмзэгт тусаж байж магадгүй л дээ.

Тийм учраас танд бас хариулах боломж олгоод байхгүй юу?

А.Намсаманд: Баярлалаа. Манай байгууллага дээр орон тоо дутуу байгаа.

Өнөөдрийн байдлаар 2 мянга орчим орон тоо дутуу. Хуулиар манай байгууллага дээр шинээр ирсэн чиг үүргүүд бий. Тухайлбал, баривчлах шийтгэлийг эдлүүлэх үйл ажиллагаа манай байгууллагад ирсэн.

Сүүлийн жилүүдэд хуулиар хоёр ч удаа ухраагаад байгаа 2017 оныг хүртэл сая. Энэ маань орон нутагт нөгөө... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Микрофон гүйцээгээд өгье.

А.Намсаманд: Орон нутагт баривчлах байруудыг хүлээж авах үйл ажиллагаа удаашралтай байгаа. Хуулийн хэрэгжилт.

Нөгөөтээгүүр зорчих эрхийг хасах ялыг бас манай байгууллага хяналт тавьж хэрэгжүүлж байгаа. Энэ маань өөрөө хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны алба хаагчдаар давхар ачаалал үүсгээд байгаа.

Тийм учраас энэ орон тооны асуудал манай байгууллагад хүндрэлтэй тусаж байгаа.

Д.Цогтбаатар: Хүндрэлтэй. Ойлголоо, ойлголоо.

Яг ийм ч байгаа болов уу гэж танайхыг энэ дээр гарч. Ямар ч гэсэн энэ бол тэмдэглэлд. Сангийн яам. Цаашдаа хэлэлцэж байхдаа холбогдох байгууллагууд үүнийгээ бас бодох хэрэгтэй. Манай Байнгын хорооны гишүүд ч гэсэн энэ дээр бодож байгаарай.

Даваагийн Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Би энэ Авлигатай тэмцэх газраас хэдэн асуулт асуух гэсэн юм.

- ▶ 2022 онд 30.9 тэрбум,
- ▶ 2023 онд 32.0 тэрбум,
- ▶ 2024 онд 45 тэрбум буюу өмнөх оноосоо 50 хувь нэмэгдэж байгаа.
- ▶ 2025 онд 54.9 хувь буюу 2024 оноос дахиад 20 хувиар нэмэгдэж байгаа.

Одоо орж ирж байгаа санал нь 53.2 тэрбум.

Ингээд Авлигатай тэмцэх газрын төсөв тодорхой хэмжээнд бид 2023, 2024 оны үед бүр эмнэлэг, сургуулиасаа харамлаад ч хамаагүй нэмсэн байна.

Тэгтэл одоо Авлигатай тэмцэх газрын үр дүнг нь харахаар бид 180 орноос 114 гэдэг байр эзэлдэг. 100 хувийн үнэлгээнээс бид 33 хувийн үнэлгээ авдаг.

Тэгээд 2026 онд орж ирж байгаа Та бүхний төсөв, орон тоо авлигаа бууруулна гэхэд хүрэх үү? Энэ төсөв, орон тоо чинь хүрэх үү гэж нэг асуулт.

Хоёрдугаарт нь, одоо яг энэ бодит жишээнүүд байгаа. Бид электрон улс болсон, e-mongol болсон. Зөвшөөрлүүдийг онлайнаар өгөөд хувийн хэвшлийг дэмжээд байгаа гэж яриад байгаа юм.

Гэтэл яг над дээр байгаа хоёр жишээ нь нэг нь шүдний эмнэлэг 6 сард хүсэлтээ өгсөн. Тэр Нийслэлийн эрүүл мэндийн газар шийддэг юм шиг байгаа юм.

Яг өөрсдийнх нь тэр программ дээр харахаар төлөв нь шийдэгдээд татгалзсан хариу өгсөн гэдэг. Нөгөө хувийн шүдний эмнэлэг хариугаа авъя гэхээр судлагдаж байгаа гэж харагдаад байдаг.

Тэгээд энэ асуудал нь шийдэгдэхгүй байна гээд 8 сард холбогдсон. 8 сард дахиад тэр газар луу нь ярьсан чинь бид судлаад болохгүй байна гэдэг хариуг нь өгсөн гээд дахиад тэр доор нь хариуг нь өгч байгаа юм.

Нөгөө байгууллага шаардсан бүх юмыг нь өгөөд байгаа юм. Тэгээд бид чинь хувийн хэвслээ дэмжинэ, эрүүл мэндээ дэмжинэ гээд байгаа. Энд чинь авлига буурахгүй байгаатай холбоотой хувийн хэвшил дээшилж чадахгүй байна гэдэг дээр нэг асуулт гарч ирээд байгаа юм.

Хоёрдугаар жишээ нь. Одоо энэ барилга барьж байгаа компаниуд бас байгаа юм. Улсын сургууль барих гээд барилга барих эрхтэй компани өөрийнхөө газар дээр зургаа батлуулсан, эскизээ батлуулсан, бүх юм нь баталсан байхад барилга үргэлжлүүлэх зөвшөөрөл гэдэг юмыг бас хаанаас олгодог юм бүү мэд. Энэ нийслэлээс л юм шиг байгаа юм. Бас олгож чаддаггүй.

Тэгээд бид цахимжаад байна, хүнээс хамааралгүйгээр цахимжаад байна гэсэн. Цахим дээр нь дахиад авлига гараад байгаа байхгүй юу.

Авлига ерөөсөө буурдаггүй. Тэгээд бид хэзээ энэ Хятад Улс шиг авлигачдаа, дарга нараа яг энэ хурал дээрээс нь бариад гарч чаддаг болох вэ? Энэ дээр энэ Авлигатай тэмцэх газраас хариулж чадах эсэхийг одоо бас тодруулъя. Тэгээд чадахгүй бол одоо энэ Авлигатай тэмцэх газрын мэдээллийг Улсын Их Хурал дээр ч юм уу мэдээлэл авч баймаар байна.

Авлига нь буурахгүй байна шүү дээ. Дарга дагасан авлига тэр чигээрээ яваад байна. Энд чинь бид нэг төсөв. Тийм баян улс юм уу? Дунджаар бид Авлигатай тэмцэх газарт жилд 50.0 тэрбум төгрөг өгч байна. Авлига буурдаггүй. Буурахгүй юм бол Авлигатай тэмцэх газрын хэрэг ч юу байгаа юм. Энэ дээр нэг хариулт авъя.

Д.Цогтбаатар: Авлигатай тэмцэх газраас хариулъя. Индрийн микрофоныг өгье.

3.Баасанням: Ирэх жилийн төсвийн төсөл Авлигатай тэмцэх газрын хуулиар хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд хүрэлцэх үү гэж байна.

Энэ зарим нэг талаараа дутагдалтай байгаа. Жишээ нь, гадаад томилолт гэдэг юм уу. Энэ нь өөрөө нийт төрийн байгууллагууд дээр гадаад томилолтыг танасантай холбоотой нэлээн буурч батлагдсан. Энэ нь өөрөө гадагшаа гарсан, хулгайлагдсан хөрөнгийг буцаан авчрах чиглэл дээр ажиллах ажил дээр бас нэлээн эрсдэл учирч болзошгүй юм уу гэж харагдаж байгаа.

Одоогийн байдлаар үндсэндээ нийтдээ гадаадаас хулгайлагдсан хөрөнгө 19.3 сая долларын хөрөнгийг буцаан авчраад байгаа. Энэ нь өөрөө нэг удаагийн явалтаар гэдэг юм уу, маш богино хугацаанд үр дүн нь гардаггүй нэлээн ажил аргачлал орж байж шийдэгддэг ийм ажлууд байгаа.

Зөвхөн мэйл явуулаад тэрийг хүлээгээд суух юм бол гаднаас хөрөнгө буцаах, авчрах ажил удаашралтай явдаг, хүндрэл бэрхшээлтэй байдаг болохоор заавал ч үгүй зарим тодорхой тохиолдлууд дээр газар дээр нь очиж уулзах тодруулах, ярилцах, үндэслэлээ тайлбарлах, тухайн орны эрх зүйн орчинд нь тохируулан шүүх, прокурор гэдэг юм уу, тухайн тусгай байгууллагатай нь хамтарч ажиллах чиглэлээрээ бас зайлшгүй хийх ажлууд байдаг.

Тэгэхээр энэ чиглэл дээр бас жоохон хүндрэл учрах болов уу гэсэн юм харагдаж байгаа.

Батлагдсан төсвийн хувьд энэ дээр би төсөв ярьж байгаа болохоор төсөвтэй холбогдуулаад. Мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд энэ жилүүдэд хохирол нөхөн төлүүлсэн тоог бас энэ дээр хэлье гэж бодож байна.

- ▶ 2020 онд 27.0 тэрбумын төсөвтэй ажиллаад 35.6 тэрбум төгрөгийн;
- ▶ 2021 онд 29.7 тэрбумын төсөвтэй ажиллаад 96.2 тэрбум төгрөгийн;
- ▶ 2022 онд 33.3 тэрбумын төсөвтэй ажиллаад 2.3 их наяд төгрөгийн;
- ▶ 2023 онд 33.1 тэрбумын төсөвтэй ажиллаад 238.7 тэрбум төгрөгийн;
- ▶ 2024 онд 48.0 тэрбумын төсөвтэй ажиллаад 240.0 тэрбум төгрөгийн хохирлыг бодитойгоор нөхөн төлүүлж ажилласан байгаа юм.

Авлигатай тэмцэх газар аж ахуйн тооцоот үйл ажиллагаа явуулдаг байгууллага биш. Гэхдээ улсын төсвийг тодорхой хэмжээнд зарцуулж байгаагийн хувьд үүнийг аль ашигтай, бодитой, бас үр дүнтэй байх чиглэл дээр нь юун дээрээ анхаарч ажиллаж байна гэдгийг.

Авлигын улмаас зөрчигдсөн тэр эрхийг, хохирсон хохирлыг нөхөн төлүүлэх чиглэл дээр нэлээн анхаарч ажилласны үр дүнд батлагдсан төсвөөсөө

3-аас 4 дахин гэдэг юм уу, нугалагдсан энэ хохирлыг бодитоор нь барагдуулж ажилласан.

Д.Цогтбаатар: Нэмж хариулах уу, эсвэл болчхов уу?

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын 2026 оны төсөв төрийн төслүүдтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Ц.Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би уг нь асуулт асуух байсан юм. Тэгээд манай бүлэг хуралдаад, бүлэг дээр бас Оюу Толгойтой холбоотой чухал асуудал хэлэлцээд байгаа учраас орж гарч байгаад бас боломжоо алдлаа.

Нэг зүйлийг л хэлмээр байна. Өнөөдөр Монгол Улсад донтолтын өвчин маш их байгаа. Энэ нь өөрөө эргээд гэмт хэргийн хохирогч болдог. Нэг бол гэмт хэргийг үйлдэх тэр сэдлийг энэ хүмүүс маш амархан бий болдог. Өөрсдөө. Мансуурах донтой хүмүүс их байна. Архины хамааралтай буюу архины донтолтой хүмүүс их байна. Дэлгэцийн донтой хүмүүс байна. Мөрийтэй тоглоомын донтолтой хүмүүс байна.

Энэ бол нэг талдаа анагаах ухааны шинжлэх ухаан талаасаа өвчин байхгүй юу. Энэ өвчинтэй тэмцэхэд ерөөсөө манайд төсөв дээр мөнгө байдаггүй юм бараг.

Манай архины эмчилгээний Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тэр Багахангай дээр л 30 хүрэхгүй ортой эмнэлэг л байгаа. Ийм байдалтай байна.

Тэгээд өнөөдөр энэ залуучуудаа эмчлээд, хөдөлмөрийн зах зээл дээр гаргах, буцаад амьдралынхаа чигийг олоод явах энэ боломжийг бид тогтолцооны хувьд болон бодлогын хувьд гаргаж өгөх ёстой юм. Үүнийг нь өнгөрсөн парламентын үед архины чиглэлээрх буюу хууль тогтоомжийг өөрчлөөд архины хуулийн дагуу Засгийн газрын тусгай сан бүрдүүлсэн юм. Энэ Засгийн газрын сан дээр нь хувийн хэвшил буюу хатуулаг өндөртэй архи үйлдвэрлэж байгаа компани литр тутамдаа 300 төгрөг хийж байгаа юм. Энэ төсвийн мөнгө биш. Энэ мөнгөний зориулалтыг бүр хууль дээр тодорхой заасан. Энэ чиглэлийн эмнэлэг, ор дэр, эмч, тоног төхөөрөмжийг бэлдэнэ гээд. Зарцуулалт нэг төгрөг ч байхгүй.

Тэгээд энэ жилийн төсөв дээр Засгийн газрын тусгай сан учраас 88-хан сая төгрөг гээд. Энэ сангийн удирдах зөвлөлийг жишээ нь Хүнсчдийн холбоо болон хувийн хэвшил буюу үйлдвэрлэгч талаас 50 хувь бүрдүүлдэг байхгүй юу.

Эд нар ингээд нийгмийн энэ асуудал дээр санаа зовоод мөнгөө гаргая гээд байхад Сангийн яам нь аваачаад үүнийг 88-хан сая төгрөгөөр тавьчихаж байгаа байхгүй юу.

Одоо тэр санд 20 тэрбум төгрөг байгаа. Эмнэлгүүд баригдаж байгаа. Баянхонгорт барья. Тайширын Тажир билүү, Тайшийн ханд барья гэсэн байгаа. Дорнодод барья гэсэн байгаа.

Тэгээд ийм хувийн хэвшлийн өөрсдийнх нь санаачилгыг үгүй хийгээд байж болох юм уу. Ийм харамсалтай зүйлүүд байх юм. Би энэ дээр уг нь Сангийн яамнаас албан ёсны байр суурь авмаар байна.

Энэ харилцаа холбооны зохицуулах жилийн нийтийн үйлчилгээний үүргийн сан гэж байдаг. Яг ялгаа байхгүй. Хувийн хэвшлийнхэн өөрөө мөнгөө өгөөд энэ сүлжээгээ өргөтгөдөг.

Энэ чинь өөрөө нийгэмд аюултай буюу яах вэ мэдээж хэрэглэгчийн өөрийн сонголт. Архи үйлдвэрлэж байгаа этгээдүүд өөрсдөө нийгмийн хариуцлагын хүрээнд ухамсарлаж байгаа байхгүй юу. Тэгээд энэ санаачилгыг нь одоо ингэж байхгүй болгож байгаа. Ерөнхийдөө төсөвтэй хольж хутгаад байхгүй болгох гээд байна.

Тэгээд энэ мансуурч байгаа буюу энэ дэлгэцийн, хар тамхины, архины, мөрийтэй тоглоомын донтолттой хүмүүсийг чинь хаана эмчлэх гээд байгаа юм бэ. Үүнийг чинь шинжлэх ухаан, Нэгдсэн Үндэстний Байгууллагуудын конвенцоор үүнийг чинь өвчин гээд зарласан шүү дээ. Эмчлэх ёстой. Боломжийг нь олгох ёстой.

Тэгээд суурь юм руугаа ерөөсөө байхгүй. Одоо тэгээд харамсалтай л байна. Яах вэ, тэгээд энэ хууль зүйн салбарын асуудлыг нийтлэг байдлаар авч үзэх боломжгүй шүү гэдэг зүйлийг манай Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамныхан ухамсарлаарай.

Хүний эрхийн зөрчилтэй оронд хөрөнгө оруулалт орж ирдэггүй юм. Хүний эрхийн зөрчилтэй орны зээлжих зэрэглэл буурдаг юм. Бид хууль сахиулах байгууллага, хүний эрхийг дээрдүүлж байж Монгол Улсын хөрөнгө оруулалтын ерөнхий орчныг сайжруулдаг юм.

Тэгээд хамгийн чухал хэсгүүдээсээ аваачиж хавтгайд нь ерөөсөө зарчимгүйгээр хасаж байгаад би үнэхээр ойлгохгүй л байгаа. Үүний өртөг буцаад л бид тэгээс эхэлнэ гэдэг шиг дахиад маш өндөр зардалтайгаар хийнэ. Угаасаа ойлгомжтой. Ийм зүйл байх юм.

Тэгээд ерөнхийдөө төсөв дээр тодорхой байр сууриудыг илэрхийлж. Хэлэлцэгдээд явсан тохиолдолд саналууд гаргана. Сангийн яам архины сан

дээр ингэж болохгүй. Үүнийг М.Санжаадорж дарга, Ж.Ганбат дарга, Б.Тэлмүүн дарга мэдэхийн дээдээр мэдэж байх ёстой доо.

Тэгээд энэ дээр хэдэн эмнэлэг бариад энэ чинь бас нэг буцаагаад амьдралд алхаг л дээ. Хөдөлмөрийн зах зээл дээр дундаж хэмжээний ажилчдыг буцаагаад... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Микрофонд гүйцээгээд өгөх үү. 1 минут. П.Сайнзориг гишүүний микрофоныг.

П.Сайнзориг: Нийгмийн тэр хэсэг дээр чинь ингээд учраа олохгүй байна шүү дээ. Ар гэртээ дарамт болсон.

Тэгээд энэ сангийн чинь удирдах зөвлөл буюу хяналтыг өөрөө хувийн хэвшил хийж байгаа юм. Хувийн хэвшил өөрөө төслөө сонгож байгаа юм. Хувийн хэвшил Баянхонгор дээр, Дорнод дээр, Улаанбаатар дээр донтолтын эсрэг эмнэлэг барья гээд өөрсдөө шийдлээ гаргаж байгаа юм.

Тэгэхээр үүнийг нь та хэд дэмжээд өгчхөөч. Энэ бол гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх манай алба хаагчдын ачааллыг бууруулах хамгийн том юм болно шүү. Айл өрхүүдийн бас ачааллаас бууруулах хамгийн том алхам болно шүү. Айл болгонд л бараг нэг архины хамааралтай хэцүү хүмүүс байна. Хаана хандахаа мэдэхгүй байна.

Тэгэхээр та хэд үүнийг ойлгоод бас нэг жоохон уян хатан хандчихаач. Би одоо 2 жил төсөв дээр ерөнхий бодлогоороо зарчим гээд дуугүй байлаа. Дуугүй байгаад байх тусам зарчим алдагдаад байгаад харамсаж байна.

Одоо энэ жилээс ярина.

Д.Цогтбаатар: О.Алтангэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Улсын Их Хурлаас баталсан төсөв үр дүнтэй зарцуулагдах ёстой. Тодорхой үр дүн гарах ёстой.

Тэгэхээр энэ хуулийн салбарын асуудал. Би салбарын сайд нь байсан болохоор биш, энэ салбарт ажиллаж, өмгөөлөл хийж, хүний эрх хамгаалж явсны хувьд төрийн байгууллагад нь ажиллаж Шүүхийн ёс зүйн хорооны даргад байсны хувьд энэ салбарын талаар ойлгуулж үг хэлэх гэж байгаа юм.

Тухайлах юм бол ноднин төсөв хэлэлцэх үеэр албан хаагчдын орон тоотой холбоотой хасна, нэмнэ гээд бөөн юм болсон. Түрүүн тэр шийдвэр гүйцэтгэл ярьж байгаа. Хязгаарлалт тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлдэг болсон. Энэ чинь камер хараад суух, хүн хянах хүн, зөрчил гаргавал очих хүн гээд зөндөө олон орон тоо хэрэгтэй. Хангалттай баталж өгөөгүй шүү дээ.

Энэ жил тэгэнгүүт тэгшитгээд 9 хувь хасна гэж байгаа. Гэтэл ноднин тэр хэлтэй амтай төсвөөр чинь манай цагдаагийн байгууллага жишээлбэл эргүүлийн машинаа нэмэгдүүлээд дуудлага мэдээлэлд хурдан очдог болсон. Энэ хэнд хэрэгтэй болсон юм. Ард түмэнд л хэрэг болж байгаа.

Өнөөдөр шүүхийн шийдвэр гараад биелдэг байвал энэ улсад юунд хэрэгтэй юм. Монгол Улсад хууль ёс тогтоход л хэрэгтэй байгаа. Хууль зүйн салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалт, хууль зүйн салбарт хийж байгаа бүх зүйлүүд энэ улсад хүнийг амгалан тайван амьдрах, хүний эрх, эрх чөлөө хангагдахад зориулагдаж байгаа юм.

Тийм учраас би П.Сайнзориг гишүүний хэлсэн үгтэй санал нэг байна. Нийтлэг байдлаар үүнийг танана, хэмнэнэ гэж үзэж болохгүй.

Улсын Их Хурлаас бодлого гаргаад хуулиуд баталдаг. Яг энэ Улсын Их Хурлаас баталсан хуулийн хүрээнд Монгол Улсад цагдаагийн байгууллага хэдэн мянган албан хаагч дутуу байгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага адилхан.

Өнөөдөр гадаадын харьяат гэхэд л маш цомхон орон тоотойгоор асар том чиг үүрэг хэрэгжүүлээд явж байгаа шүү дээ.

Өнөөдөр шүүн таслах ажиллагаанд орж байгаа өмгөөлөгч болгон, шүүн таслах ажиллагааны оролцогч болгон

- шүүхийн орчин нөхцөл муу байгаа тухай,
- шүүх хуралдааны танхим олдохгүй байгаа тухай,
- шүүх хуралдаан хойшилж байгаа тухай,
- хэтэрхий жижигхэн байгаа тухай ярьж байгаа.

Ингээд шүүхдээ олигтойхон шиг ч байр барьж өгдөггүй.

Тэгээд жилийн жилд төсөв ярихаараа хасна, танана гэдэг зүйл ярьдаг. Дорвитой шийдэж чаддаггүй. Дорвитой шийдэж чадахгүй болохоор хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаа жигдэрч чаддаггүй.

Ингээд л дараагийн жилтэй золгодог. Тэгээд л хэдэн байгууллагынх нь дарга нар манай төсвийг ингээд батлуулчихмаар байна гээд өөрсдөө авч байгаа юм шиг ингээд явдаг.

Тэгээд гишүүд нь хасаж, танах болохоороо эндээс хасаад ханачихъя, үүнээс авчихъя гээд хаячихдаг. Одоо жишээлбэл шүүх шинжилгээний байгууллага гэхэд л өчнөөн тоног төхөөрөмж, бүсийн төвүүдийн барилгууд хэрэгтэй л байгаа шүү дээ. Өнөөдөр мөөгөнцөртсөн, ашиглалтаас гарсан байран дотор яваад л албан хаагчид үйл ажиллагаагаа хийж байгаа.

Хүний эрхийн Үндэсний Комиссын байнга дүгнэлт гардаг. Үүнийгээ засаач ээ гэсэн цагдан хорих байрууд байгаа шүү дээ. Энд төсөв тавихгүй бол тэр яаж сайжрах юм. Хүний эрхийн нөхцөл байдал яаж сайжрах юм гэдэг ийм нөхцөл байдал байгаа юм.

Шийдвэрлэх бололцоотой зүйлүүд ч байгаа. Жишээлэх юм бол тэр 88-хан сая төгрөг тэр архины сан дээр тавьдаг. Юу гэсэн үг юм. Энэ чинь төрийн мөнгө биш шүү дээ. Ноднин нэг санаачилга гаргаад л 1 тэрбум төгрөгөөр хязгаарлана гээд л ингэсэн. Тэрний дараа яваад миний бие жишээлбэл Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр олон гишүүдтэй уулзаад ирэх жил энэ мөнгийг нээгээд өгөөрэй. Энэ Маантад донтогчдод зориулсан эмнэлэг баръя хэдүүлээ гээд л яриад явж байсан зүйл өнөөдөр 88 сая төгрөг ч гэнэ үү, ийм мөнгө болоод л ороод ирж байна.

П.Сайнзориг гишүүний шүүмжлэх нь аргагүй шүү дээ.

Тэгэхээр хууль зүйн салбарын хөрөнгө оруулалт, хууль зүйн салбарын төсөв гэдэг бол энэ нь өөрөө нийгэмд монгол хүний эрх, эрх чөлөөг хэрхэн яаж хамгаалах вэ, монгол хүний амар амгалан байдлыг яаж хамгаалах вэ, сахих вэ гэдэгтэй туйлын холбоотой төсөв шүү.

Хүний эрхийн төлөв байдалд шууд хамаардаг ийм төсөв шүү. Ийм учраас хасна, танана гэлгүйгээр энэ асуудал дээр нэлээн нухацтай хандаж дэмжиж өгөхийг нийт гишүүддээ уриалъя.

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Би асуусан асуулттайгаа холбогдуулж үг хэлье.

Тийм. Манай Сангийн яам нийтдээ ер нь улсын хэмжээнд 226 мянга 685 төрийн албан хаагчдаас 9 хувийн цомхотгол хийхээр үндсэндээ 20 орчим мянган төрийн албан хаагчдын асуудлыг ирэх жил хөндөх гэж байгаа юм.

Тэгээд сая Сангийн яам өөрөө хариулж байна. Чиг үүргийн шинжилгээ хийх ёстой гэж.

Өнөөдөр чиг үүргийн шинжилгээ хийсэн нэг ч байгууллага байхгүй. Энэ чиг үүргийн шинжилгээг

- хэн хийх юм,
- яаж хийх юм,
- өөрөө хийх юм уу,
- хөндлөнгийн байгууллагаар хийлгэх юм уу.

Хөндлөнгийн байгууллагаар хийлгэхээр төсөв мөнгийг нь хэн гаргах юм, хаанаас гаргах юм гээд.

Энэ бол би бодлогоор нэгдсэн журмаар хийх ёстой ажил гэж ойлгож байгаа. Түүнээс зүгээр байгууллагын дарга өөрөө өөр дээрээ дотооддоо чиг үүргийн шинжилгээ хийнэ гээд. Энэ одоо яаж хийх юм бэ гэдэг аргачлал, арга зам, энэ талаар ойлголт юу ч байхгүй байгаа. Байхгүй байгаа.

Тийм учраас энэ чиг үүргийн шинжилгээ гэдэг юмыг Улсын Их Хурлаас баталсан 85 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг цаашид нэг мөр тодорхой болгох тал дээр Засгийн газар тодорхой ажиллах хэрэгтэй байна. Тодорхой мэдээлэл өгөх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол энэ 9 хувийн цомхотгол чинь нэг даргын үзэмжээр хийгддэг асуудал болох гээд байна шүү.

Байгууллага дээрээ жаахан шударга юм хэлдэг. Болохгүй, бүтэхгүй байгаа зүйлийг нь хэлдэг, дуугардаг, ярьсан хүнийг ад үздэг цомхотгол болох вий дээ. Уг нь хаана аль ажлын байр давхардсан чиг үүрэгтэй байна вэ гэдэг юмыг л гаргаж ирж байж цомхотгол хийх гээд байгаа байгаа юм шүү дээ.

Гэтэл үүнийг хийгээгүй байж байж цомхотгол хийгээд эхлүүлсэн байгаа. Энд олон төрийн албан хаагч нар гомдолтой байгаа. Үүнийгээ байгууллагын дарга нь өөрөө хий гэж Засгийн газар чиг үүрэг өгөөд байгаа юм уу. Засгийн газраас нэгдсэн бодлогоор Хэрэг эрхлэх газраас гэдэг юм уу, хаанаас юм нэгдсэн шалгалт хяналтаар хийх юм уу. Энэ маш тодорхойгүй байгаа.

Тийм учраас Сангийн яам үүнийг тодорхой болгох хэрэгтэй. Хэрвээ болгоно. Тодорхой болгоод байгууллагын дарга нар нь өөрсдөө хийнэ гэвэл төсөв мөнгө бас энд хэрэгтэй. Тэрийг хэн хийх юм. Хүний нөөцийн дарга нь хийх юм уу. Ямар журмаар хийх юм. Нэгдсэн журам, стандартаар хийх юм уу. Энэ ямар ч нэгдсэн ойлголтгүй яваа.

Тийм учраас үүнийг нэгдсэн байдлаар, нэгдсэн чиг үүргийн дагуу хийхгүй бол байгууллагын дарга болгон өөр өөрөөр ойлгож, өөрийн ойлгосон хүрээнд өөр өөрийн байдлаар цомхотголуудыг хийж, төрийн албыг эргээд тогтворгүй байлгах нөхцөлийг бүрдүүлж байна гэж би хэлэх гэж байгаа юм.

Тийм учраас энэ дээр Та бүхэн, Сангийн яам, Засгийн газар энэ дээр онцгой анхаарал хандуулж ажиллаач ээ. Төрийн албан хаагч нар хийх зүйлээ ядаад байгаа улсууд биш шүү дээ. Тангараг өргөсөн. Өмнөх ажилдаа түүртсэн... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Нэмж авах уу? Л.Мөнхбаатар гишүүний микрофоныг өгье.

Л.Мөнхбаатар: Хууль зүйн байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд болох Хууль зүй, дотоод хэргийн яам, шүүх эрх мэдлийн болон бусад байгууллагуудын төсвийг хэлэлцэж байна.

Мэргэжлийн Байнгын хорооны хувьд манай Хууль зүйн байнгын хорооны гишүүд харьяа байгууллагуудынхаа төсөв, түүний онцлог, ажил албаны жаргал, зовлон, орон тоо гээд олон асуудлуудыг хөндөж санаа зовниж ярьж байгаа.

Ер нь Хууль зүйн байнгын хороо харьяа байгууллагуудынхаа төсөв дээр онцгойлон анхаардаг. Хасуулахгүй байх. Харин ч нэмэх. Хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлэхүйц хэмжээнд байлгах гэж хичээдэг ийм Байнгын хороо.

Тийм учраас Хууль зүйн байнгын хорооныхоо гишүүддээ талархаж байгаагаа илэрхийлье.

Улсын төсөв хүндрэлтэй болсон. Хүнд байгаатай холбогдуулаад дандаа хэмнэлтийн горимтой байгаа ийм төсвийг бид хэлэлцэж байгаа. Засгийн газар кабинетын зарчим байна. Яривал зовлон жаргал нэлээн их байна. Гэхдээ нэгэнт өргөн баригдсан төсөв учраас тэр хүрээндээ л ярина.

Хөрөнгө оруулалтын хязгаар, урсгал зардлын болоод тоног төхөөрөмж гээд олон зардлууд дээр Сангийн яам тодорхой хязгаар тогтоож өгдөг. Энэ хязгаарууд дээр Сангийн яамтай бас нэлээн ойлголцож ажилласан. Үүнийг бас хэлэх нь зүйтэй байх.

Тодорхой хэмжээнд тавьсан хязгаарууд тун бага. Гэхдээ салбарынхаа ажил, албаны онцлогууд, хуулиар хүлээсэн үүргүүд, нөхцөл байдалтайгаа уялдуулаад бас тодорхой хэмжээнд ойлголцоод энэ төсвөө оруулж ирж байгаа. Үүнийг хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Сая харин хэд хэдэн гишүүд, П.Сайнзориг гишүүн, О.Алтангэрэл гишүүдийн ярьж байгаагаар архидаан согтуурахтай тэмцэх тусгай сан байгаа юм. Энэ бол өөрөө төсвийн мөнгө бол биш байгаа юм. Төсвийн мөнгө бол биш. Энэ төсөвтэй биш тусгай сан учраас хувийн аж ахуйн нэгжүүдээс орж ирж байгаа орлого. Тэгээд үүний зарцуулалтыг нь Сангийн яам харин эргэж харж үзэж хэлэлцүүлгийн явцад ярих нь зүйтэй. Ярих нь зүйтэй. Гишүүд ч сая ярина гэдгээ хэлж байх шиг байна.

Одоо энэ жил 88 сая төгрөг тавьсан байгаа. Үүгээр энэ чиглэлийн ямар ажил хийх вэ дээ. Тийм ээ. 20 орчим тэрбум төгрөг байна. Үүгээр эмнэлэг, урьдчилан сэргийлэх, донтолт, хар тамхи, архидалт бусад донгууд байна. Эдгээртэй тэмцэх энэ ажилд зориулалтын дагуу зарцуулаад явах нь зүйтэй гэдэг байр суурьтай байгаа юм.

Тийм учраас хэлэлцүүлгийн явцад гишүүд хөндөж ярих байх. Үүнийгээ өөрсдийнхөө бүрэн эрхийн хүрээнд яриад явах байх гэж би бодож байгаа юм.

Төсвийг дэмжиж байгаа Байнгын хорооны хорооныхоо гишүүдэд баярлалаа.

Д.Цогтбаатар: Би хэдэн зүйл хэлнэ.

Түрүүн Х.Баасанжаргал гишүүн шалгуур үзүүлэлтүүдийн тухай ярьж байна. Энэ үнэхээр чухал шүү. Энэ системд иргэд итгэж байна гэмээ нь Монголын төр, иргэдийн хоорондын итгэлцэл. Энэ итгэлцлийн гол суурь нь энэ салбараас, манай байнгын хорооны эрх мэдлийн хүрээнд хамарч байгаа байгууллагуудад итгэх итгэлээс төр, иргэний харилцааны итгэлцлийн суурь үүсэж гарч байгаа.

Тэгэхээр энэ дээр тэр шалгуур үзүүлэлтээр бид хэр ажил ахиж байна, иргэдийн итгэлийг хэр олж авч байна гэдгийгээ тогтоож чадахгүй бол яг эндээс чинь болоод л иргэд төрд итгэхгүй байгаа. Тэгээд төрд итгэхгүй болохоороо бүгдийг нь үзэн ядаж эхэлж байгаа. Энэ чинь өөрөө жинхэнэ энэ төрийн хамгийн том эрсдэл болж байгаа юм. Иргэн төрдөө итгэхгүй байгаа тохиолдолд энэ төр өөрөө тогтвортой, үр ашигтай ажиллаж чадахгүй.

Тэгэхээр нэг салбарын ажиллагаа аягүй том суурь ойлголтын үзүүлэлт байгаа учраас шалгуур үзүүлэлт дээр би бүр Х.Баасанжаргал гишүүн, Хууль зүйн сайд хоёрт надад дээр хамт орж ирээд хэдүүлээ яг энэ дээр сууя. Үүнийг боловсронгуй болгох ёстой.

Тэгээд тэр итгэлцлийн бүр тодорхой индекстэй. Үүнийг бид хэмжүүр үзүүлэлтээр төсөв. Байнгын хороо бол салбараа дэмжээд төсвөө бид аль болох хасуулахгүй байхын төлөө. Болж өгвөл нэмэхийн төлөө. Ямар ч хүнд үед үүний төлөө яваад байна шүү дээ. Тэгэхдээ тэрний хариу юу гэхээр иргэдийг итгэх хэмжээг нь нэмэгдтэл ажиллаж өгөх. Тэр шударга мэдрэмж. Энэ төр шударга байна шүү гэдэг мэдрэмжийг нь бий болгох хэмжээнд хууль хяналтын байгууллагууд ажиллах л хэрэгтэй. Бидний хүсэж байгаа ганцхан юм ердөөсөө л энэ.

Тэгэхээр энэ дээр тэр шалгуур үзүүлэлтгүй бол хэдүүлээ тал талдаа явахгүй ээ. Шалгуур үзүүлэлт зүгээр хэлбэр төдий байгаа тохиолдолд энэ дээр явахгүй ээ. Мөнгө тавьж өгч байгаа бол хариу нэхнэ. Ард иргэдийн төрд итгэх итгэл нэмэгдэхэд хамгийн гол үүрэг гүйцэтгэх энэ салбар сайн ажиллах ёстой. Харагдахуйц ажиллах ёстой.

Тэгэхээр энэ дээр би тодорхой чиглэл өглөө. Х.Баасанжаргал гишүүн, Хууль зүйн сайд хоёрт энэ дээр би хамтраад ажиллахад бэлэн байгаа. Хамт суугаад энэ дээр явъя. Байгаа шалгуур үзүүлэлтүүдээ өшөө боловсронгуй болгох, нээлттэй болгох, ард иргэд хараад энд өөрсдөө тэр дүгнэлтэд оролцох боломжтой болгох хэрэгтэй.

Хүний эрхийн комиссын тал дээр бас нэг зүйлийг яримаар байна. Энэ хуульд өөрчлөлт оруулах ёстой. Энэ хэрэг хянан шад шалгах үйл ажиллагаанд, ер нь энэ эрүүгийн процессын хуульд Хүний эрхийн комиссын оролцоог хангаж өгөх ёстой шүү.

Энэ үүднээсээ бид төсвөө хэлэлцэж байхдаа ч энэ юмнуудаа бас бодолцож ярьж байх ёстой. Тэгэхгүй бол зөвхөн хүний эрхийн зөрчил гарсан хойно нь Хүний эрхийн комиссыг оруулах боломжийг нээж өгөөд байна гэдэг. Хүний эрхийн зөрчил, процесст гарахыг уриалсан, урьсан ийм хуулийн тогтолцоо яваад байна гэсэн үг.

Тэгтэл хууль чинь өөрөө урьдчилан сэргийлж яах ёстой. Энэ дээр энэ хуулийн санаачилга орж ирэх ёстой. Сая энэ хэлэлцүүлэг дунд зах зухаасаа гараад л байна.

Тэгэхээр Х.Баасанжаргал гишүүн хүний эрхийн тухай нэлээн ярьдаг хүн. Үүнийг надтай хамтарч ажиллаж энэ дээр ажиллана шүү.

Гурав дахь юм нь, П.Сайнзориг гишүүний түрүүний хэлээд байгаа донтолт.

Ер нь хуулийн салбарт сэтгэл зүйн чиглэлийн судалгаа, шинжилгээ. Үүнийг бодлогодоо, хууль хэрэгжүүлэх явцдаа өнөөдрийн ашиглаж хэрэглэж байгаагаасаа хамаагүй илүү гүнзгий ашиглах шаардлага байгаа шүү. Энэ дээр бид бас тэр төсөв тал дээр нь бодож анхаарах ёстой.

Тэгээд сүүлийн миний хэлэх гэж байгаа юм бол энэ 9 хувиар орон тоо цомхотгоно гэдэг. Би ингэж бодож байгаа юм. Энэ ингээд ташраар нь. Цаанаа хүний ажил, хувь заяаны асуудал байгаа. Иргэд төр өөрийгөө томсгоод, нэмээдэх гэж ерөөсөө гуйгаагүй шүү дээ.

Энэ дотор явж явж баахан нэмээд, өчнөөн хүнийг ажлын байртай болгочхоод цаанаа ипотекийн зээлтэй, тэжээж байгаа үр хүүхэдтэй хүмүүс байж байгаа шүү дээ. Тэгэнгүүт нэг өдөр дарга нар за одоо хасъя. 9 хувь. 8.5 гэж хэн яагаад хэлээгүй юм? 7 гэж яагаад хэлгүй юм. Яагаад 9. Хэн 9 гэдэг тоо гаргаж ирсэн юм.

Ялангуяа манай энэ салбарт 9 гэдгийн ард хэчнээн хүний амьдрал байхгүй болох вэ. Би хамгийн их төрийн эрх мэдлийг хумих, төсвийг багасгах тухай ярьдаг хүн.

Тэгээд багасга гээд ярьсан чинь багасгаж байгаа нь энэ. Яасан их та нар хас гэж ярьдаг юм гэнгүүтээ шууд нэг ийм тоо оруулж ирээд хасдаг юм уу. Ингэж хүний амьдралаар тоглодог юм уу.

Тэгэхээр энэ дээр энэ хасах тоогоо тэр өөр салбарууд дээр индекс тавьж байгаад янз янзаар хасах ёстой. Амьдралд нийцүүлж. Энэ нийгэмд хууль байхгүй бол бусад бизнес бүх юм чинь байхгүй болно. Хуулийн хэрэгжилт байхгүй бол бусад бүх юмны эдийн засгийн өсөлтийг чинь тэр суурь нь өөрөө алга болно.

Одоо энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрынхан юу хасах нь байтугай орон тоо нь дутуу явж байна шүү дээ. Тэгээд гэмт хэрэгтнүүдээ хянаж чадахгүй бол энэ нийгмийн чинь аюулгүй байдал, тогтвортой байдал ямар байдал руу шилжих вэ. Юун эдийн засгийн хөгжил.

Тэгэхээр нэг ийм нэг цавчилтаар нэг асуудлыг эдгээх гэсэн хандлага байж болохгүй. Хасах ёстой. Хасах газраасаа хасах ёстой. 20 яам байна шүү дээ. Тэнд хэчнээн байгууллага давхацсан байгаа юм.

Прокурорын байгууллага, цагдаагийн байгууллага, шүүх давхцаад байгаа юм уу. Энэ чинь тус тусдаа заавал төрд. Төр оршин тогтнож байгаа бол заавал байх ёстой байгууллагууд. Эд нар дээр яриа байхгүй шүү дээ.

Тэр давхцаад байгаа бусад байгууллагуудаасаа хасаач ээ. Тэндээ 9 байна уу, 15 байна уу хасах хэрэгтэй шүү дээ. Бараг л жорлонгийн яам байгуулахгүй байгаа шүү дээ.

Гаднын хэлээр орчуулах гэхээр орчуулагдахгүй яамд байсан шүү дээ. Яагаад гэвэл тийм яам бусад дэлхийн өөр оронд байхгүй. Тэд нараасаа хасах хэрэгтэй байхгүй юу.

Тэгэхээр энэ юмнуудаа бид няхуур харж үзнэ. Лав л манай Байнгын хороо бол энэ дээр няхуур харж үзнэ шүү.

Тийм учраас гишүүдийн ярьж байгаа юмуудыг сайн анхаарч үзэх хэрэгтэй. П.Сайнзориг гишүүний ч гэсэн тэр яриад байгаа. Би тэр сэтгэл зүйн судалгаа гээд. Архины донтолт чинь клиник шинж чанартай өвчин байхгүй юу. Хар тамхи бас өвчин. Нэгэнт донтоод л орсон бол тэр хүн сэтгэлээр нь мянга засаад тийм амархан гардаг зүйл биш. Тэр байтугай мөрийтэй тоглоом чинь яах аргагүй сэтгэлийн өвчин. Сүүлдээ заавал эмчилгээ авч байж засрах хэмжээний юм шүү дээ.

Тэгэхээр энэ юмнуудыг бүгдийг нь төсвийг хэлэлцэж байхдаа бид сэтгэл зүйн судалгаа, сэтгэл зүйчдийн оролцоог нэмэгдүүлэх тал дээр бас л төсөв юмуудыг бодох ёстой гэж бодож байна.

Тэгээд манайхан энэ дээр ул суурьтай бүгдээрээ доор дороо ажиллацгаая. Тэгээд цааш цаашдын хэлэлцүүлэг дээрээ өөрийнхөө оруулах, нэмэх асуудлуудыг яриад явах ёстой.

Ингээд энэ асуудлаар гишүүд үгээ хэлж дууслаа. /алх цохив/

Хууль зүйн байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Хэлэлцүүлэг хийсэн талаарх танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Дараагийн асуудалдаа оръё.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл
/Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн
сонгон шалгаруулалтыг зарлах тухай/

Байнгын хорооны тогтоолын төсөл.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай.

Байнгын хорооны тогтоолын төслийг Та бүхэнд уншиж танилцуулъя. Тогтоолын төслийг тараасан байгаа. Гэхдээ би уншаад танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.

2025 оны дугаар сарын, өдөр, дугаар. Улаанбаатар хот.

“Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн хүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай”.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1.2 дахь заалтыг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 17 цаг 30 минут хүртэл хугацаанд хүлээн авч, нэр дэвшигчээр дэвшигчээр бүртгэхээр тогтоосугай.

2.Сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд мэдээлэх, нэр дэвшигчийн хүсэлт, материалыг хүлээн авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Хууль зүйн байнгын хорооны дарга /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар гэсэн тогтоолын төсөл байна. Уншиж танилцууллаа.

Та бүгдэд тараасан байгаа.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье.

Алга байна. Асуулт байхгүй байна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Одоо энэ бол санал хураалттай.

“Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

61.1 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Дараагийн асуудалдаа оръё.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн
хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий
ажлын хэсэг байгуулах тухай/

Байнгын хорооны тогтоолын төсөл. “Ажлын хэсэг байгуулах тухай”

Байнгын хорооны тогтоолын төслийг Та бүхэнд уншиж танилцуулъя. Тогтоолын төслийг Та бүгдэд тараасан байгаа. Гэхдээ уншаад танилцуулъя.

Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.

2025 оны дугаар сарын тэдний өдөр, дугаар, Улаанбаатар хот.

“Ажлын хэсэг байгуулах тухай”

Монгол Улсын Их Хурлын хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 8 гишүүнээс 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах,

санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Г.Уянгахишиг Монгол Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсгийн гишүүд

Б.Баярбаатар	Монгол Улсын Их Хурлын гишүүн
Х.Баасанжаргал	Монгол Улсын Их Хурлын гишүүн
О.Номинчимэг	Монгол Улсын Их Хурлын гишүүн
Д.Пүрэвдаваа	Монгол Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсэг /Г.Уянгахишиг/-т зөвшөөрсүгэй.

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар.

Гишүүд санал хураалтад бэлдье. Б.Пүрэвдорж гишүүн ээ, ажил хийж байхад та одоо.

Байнгын хорооны төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье. Би үүнийг нь өнгөрөөд явсан байна.

Л.Соронзонболд гишүүнээр тасаллаа. Л.Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: Зүгээр нэг ийм зарчмын асуулт байна.

Ардчилсан намын нэг гишүүн ажлын хэсэгт орох ёстой байсан уу, үгүй юу?

Д.Цогтбаатар: Энэ чинь нөгөө сурроны тухай хууль шүү дээ. Л.Соронзонболд гишүүн, С.Эрдэнэболд гишүүн хоёрыг нэмье. Яагаад гэвэл би хоёр гишүүн нэмэхгүй бол энэ чинь нөгөө тэгш тоотой болох гээд байна.

Тэгвэл энэ хоёр гишүүнийг нэмээд би тогтоолын төсөл дээрээ энэ бүрэлдэхүүнээ дахиад танилцуулъя.

Дарга Г.Уянгахишиг Улсын Их Хурлын гишүүн, Гишүүдэд Б.Баярбаатар гишүүн, Х.Баасанжаргал гишүүн, О.Номинчимэг гишүүн, Б.Пүрэвдаваа гишүүн, Л.Соронзонболд гишүүн, С.Эрдэнэболд гишүүн гэсэн гишүүдээр нэмлээ.

Гишүүд үг хэлж, асуулт авч дууслаа. Үүний дагуу хоёр гишүүний нэрийг нэмлээ.

Ингээд тэгвэл санал хураалтдаа бэлдэх үү. Тэгвэл би дахиж уншиж танилцуулъя. С.Эрдэнэболд гишүүн санаачлагчийн хувьд орж болохгүй байгаа юм байна.

Тэгэхээр одоо бол О.Алтангэрэл гишүүнийг нэмж байна. Ажлын хэсгийн гишүүнд. Ингээд Г.Уянгахишиг гишүүн ажлын хэсгийн дарга. Гишүүдээр Б.Баярбаатар гишүүн, Х.Баасанжаргал гишүүн, О.Номинчимэг гишүүн, БПүрэвдаваа гишүүн, Л.Соронзонболд гишүүн, О.Алтангэрэл гишүүн гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

Үүнийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалтдаа бэлдье гишүүд ээ.

Ажлын хэсгийн саяын уншиж танилцуулсан бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсгийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

61.1 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/ Тогтоолын төслийг хэлэлцэж баталлаа.

Тав дахь асуудалдаа орьё.

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл
/Ажлын хэсэг байгуулах тухай/

Байнгын хорооны тогтоолын төсөл.

“Ажлын хэсэг байгуулах тухай”

Байнгын хорооны тогтоолын төслийг Та бүхэнд уншиж танилцуулъя. Та бүхэнд тараасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.

2025 оны дугаар сарын, өдөр, дугаар, Улаанбаатар хот.

“Ажлын хэсэг байгуулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5 дахь хэсгийг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох хэсэгт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч

Н.Алтанхуяг

Монгол Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсгийн гишүүд

О.Алтангэрэл

Монгол Улсын Их Хурлын гишүүн

П.Сайнзориг

Монгол Улсын Их Хурлын гишүүн

Х.Тэмүүжин

Монгол Улсын Их Хурлын гишүүн

Г.Уянгахишиг

Монгол Улсын Их Хурлын гишүүн

Б.Энхбаяр

Монгол Улсын Их Хурлын гишүүн

У.Отгонбаяр

Монгол Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй.

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар.

Тогтоолтой холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье.

Нөгөө Үндсэн хуулийн цэцийн 07 дугаар дүгнэлт байх. Алга байна.

Тэгвэл саяын уншиж танилцуулсан томьёоллоор санал хураалт явуулъя.

Саяын уншиж танилцуулсан томьёоллоор энэ бүрэлдэхүүн бүхий ажлын хэсгийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтдаа бэлдье. Манайхан. Бэлдсэн байна. Санал хураалт. /алх цохив/

61.1 хувиар санал дэмжигдлээ.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталлаа. Санал хураалтын дүнг сая танилцууллаа. 61.1 хувь.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүддээ ирж идэвхтэй оролцсонд талархал илэрхийлье.

Хуралдаан 1 цаг 57 минут үргэлжилж, 14 цаг 54 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД